



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 15/д

Номгон

Баянхонгор аймгийг 2016-2025 онд  
хөгжүүлэх хэтийн зорилт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "а" заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит ХҮ хуралдаанаас ТОГТООХ нь:

1."Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ыг олон нийтэд хүргэн сурталчилах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

3."Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-той сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг жил бүр уялдуулан боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд зөвлөж, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай

4.Тогтоолын хэрэгжилтийг жил бүрийн эцэст аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцэж, үр дүнг тооцон, шаардлагатай бүтэц, төсвийг баталж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдөд зөвлөсүгэй.

5.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэлүүд нь цаашид "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ыг мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагаандаа тусгаж, аймгийн хэмжээнд баримтлах хэтийн бодлогын залгамж чанарыг хадгалж ажиллахыг намуудын удирдлагуудад уриалсугай.

6.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2005 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 4/4 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ШИРМЭН

116701

**"БАЯНХОНГОР АЙМГИЙН 2016-2025 ОНД  
ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТ"**

**НЭГ. АЛСЫН ХАРАА - 2025**

“Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон эрчимжсэн хөдөө аж ахуй аж үйлдвэр хосолсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн, тээвэр логистикийн оновчтой бүтэц бүхий ногоон хөгжлийг эрхэмлэсэн өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай, ядуурлаас бүрэн ангижарч, чинээлэг дундаж давхрага давамгайлсан, нэг хүнд ногдох орлого, эдийн засгийнхаа өсөлтөөр бүс нутагтаа тэргүүлсэн, иргэддээ сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн ухаалаг засаглалтай аймаг” болх хэтийн зорилтыг аймгийн ИТХ-аас нийт ард иргэддээ хүргэж байна.

**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ  
ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР 2025 ОНД  
ХҮРЭХ ТҮВШИН**

- 1.Нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын жилийн дундаж өсөлтийг 2016-2025 онд 35 хувиас доошгүй түвшинд барьж нэг хүнд ногдох үндэсний нийт орлогыг 6500 америк долларт хүрэх.
- 2.Ажилгүйдлийн түвшинг 2 хувьд хүргэж, ядуурлыг арилгана.
- 3.Аймгийнхаа хүн амын эрүүл, урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 75 -д хүргэнэ.
- 4.Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий 10 аймгийн нэг болно.
- 5.Эдийн засгийн өрсөлдөх чадваргаараа эхний 5-т орно.
- 6.Засаглалын хүрээнд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлсэн, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай, ухаалаг ардчилсан засаглалыг төлөвшүүлнэ.
- 7.Нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө бүс нутагтаа тэргүүлэгч аймгуудтай өрсөлдсөн, Монгол улсын хэмжээнд хөгжлөөрөө тэргүүлсэн эхний 5 аймгийн нэг болно.

## АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ҮР ДҮНГ ИЛЭРХИЙЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилтыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжилд гарах үр дүн, өөрчлөлтийг дараах 22 үндсэн үзүүлэлтээр бусад аймгуудтай харьцуулж тодорхойлно.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилтод түвшин (2025 он)
1	Эдийн засгийн дундаж өсөлт	хувиар		
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	сая төгрөг	331 491,4 12-р байр	1200 000,0 байр 5-р
3	Хүний хөгжлийн үзүүлэлт (индекс)	эзлэх байраар	0,666 19-р байр	0,935 9-р байр
4	Дундаж наслалт	жилээр	68,89 17-р байр	75,00 5-р байр
5	Ядуурлын түвшин /ажилгүйдлийн түвшин	хувиар	5,6 7-р байр	2,0 3-р байр
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байраар	46,88 20-р байр	90,00 5-р байр
7	Эдийн засгийн тамир тэнхээ	эзлэх байраар	39,03 16-р байр	74,89 5-р байр
8	Засаглалын үр ашиг	эзлэх байраар	43,68 18-р байр	83,82 6-р байр
9	Бизнесийн үр ашиг	эзлэх байраар	51,97 14-р байр	99,7 3-р байр
10	Дэд бүтэц	эзлэх байраар	42,93 18-р байр	82,38 6-р байр
11	Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувиар	69,0 18-р байр	99,0 5-р байр
12	1000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	промилээр	15,1 8-р байр	12,0 4-р байр
13	100000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	промилээр	137,4 21-р байр	Эхийн эндэгдэлгүй аймаг болно
14	Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэг хамрагдалт	хувиар	6320,0 85 хувь	90 хувьд хүргэнэ
15	Баянхонгор аймагт аялах гадаадын жуулчдын тоо	МЯН.хүн	3000	10000
16	Нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь	хувиар	0%	10%
17	ДНБ-нд боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	хувиар	2,7 12-р байр	10,0 5-р байр
18	Төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах	хувиар	• Төмс-62,0 % • Хүнсний ногоо-34,0%	• Төмс-100,0 % • Хүнсний ногоо-100,0%

19	Малын тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээ	1 малд ногдох хэмжээгээр	0,2%	10%
20	Ногсон байгууламжийн хэмжээ	га	90,0	200,0

## ХОЁР: АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН, НӨӨЦ БОЛОМЖ


### 2.1. Баянхонгор аймгийн хөгжлийн ололт, хүрсэн түвшин


Баянхонгор аймаг одоогоос 10 жилийн өмнө 82229 хүн амтай, 1 878 400 толгой малтай, 46,6 тэрбум төгрөгийн ДНБ үйлдвэрлэдэг, аж үйлдвэрийн салбар нь 16,52 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг, нийт төрийн албан хаагчдын 10 хүрэхгүй хувь нь компьютер хэрэглэдэг, хүн амын дундаж наслалт 59, Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Баян-Овсо зэрэг 4 сум өндөр хүчдэлийн шугамд холбогдож бусад 16 сум дизель цахилгаан станцтай байсан бол 2015 оны байдлаар Баянхонгор аймаг нь 3 771 867 толгой мал тоолуулж мал сүрэг нь бараг 2.0 сая шахамаар өссөн, 2014 онд 331 491,5 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэн нь 2006 оныхоос 7 дахин нэмэгдсэн, хүн амын дундаж наслалт нь 68,9 болж дасуй 10 насаар нэмэгдсэн, 2012 онд аймгийн хэмжээнд 31,4 км инженерийн шугам сүлжээ байсан бол 2015 онд 63,2 км болж 2 дахин нэмэгдсэн, Баянхонгор хотын хэмжээнд нийт 24,7 км хатуу хучилттай авто замтай болсноор хатуу хучилттай замын хэмжээ нэг дахин нэмэгдсэн, 2012 оны жилийн эцэст аймгийн төвд 1050 айл нийтийн орон сууцанд амьдарч байсан бол сүүлийн 3 жилийн хугацаанд 1136 айл шинэ орон сууцанд орсон зэрэг ахиц, дэвшилд хүрсэн байна.

Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилтыг боловсруулахдаа аймгийнхаа хөгжлийн өнөөгийн түвшинг бусад аймгуудтай харьцуулан шинжилж, дүгнэлт хийхийг хичээсэн болно.


### ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Баянхонгор аймгийн ДНБ-ны сүүлийн 4 жилийн үзүүлэлт  
Баянхонгор аймагт сүүлийн 4 жилд үйлдвэрлэсэн ДНБ-ний бүтэц (хувиар)





Баянхонгор аймагт үйлдвэрлэсэн ДНБ нь жил дараалан өсч байгаа хэдий ч бусад аймгуудтай харьцуулахад улсын дундажаас хойгуур үзүүлэлттэй байна.  
 2014 онд үйлдвэрлэсэн ДНБ /сая төгрөг/



### ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР


Нийт малын тоогоор улсын хэмжээнд эзэлж байгаа байр суурь



Малын төрөл тус бүр дээр улсад эзлэж байгаа байр /2014 оны дүн/


Малын төрөл	Малын тоо/толгойгоор/	Улсад эзлэх байр
Ямаа	2, 138, 102	I
Тэмээ	41, 668	II
Үхэр	170, 767	IX
Адуу	126, 311	XI
Хонь	989, 016	XIII

Баянхонгор аймгийн мал сүрэг жил дараалан 5 төрөл дээрээ өсч байгаа нь сайн үзүүлэлт боловч бэлчээрийн даац тэр хэмжээгээрээ хэтэрч байгаа нь санаа зовоосон асуудал юм. Иймээс малаа чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар малынхаа тоо толгойг цөөлөх бодлогыг цаашид баримтлах нь зүйтэй гэж үзэж



байна.


Баянхонгор аймгийн бэлчээрийн даац 2015 оны байдлаар



Аймгийн төмс, хүнсний ногооны хэрэгцээ

Баянхонгор аймагт инженерийн хийцийн 17 услалтын системийн нийт 425 га талбайд тариалалт эрхлэх бололцотой ч одоогоор нийт талбайн 20 хүрэхгүй хувийг ашиглаж байна. Манай аймаг нийт усалгаатай талбайны 40 орчим хувьд нь дэвшилтэд технологи ашиглан төмс, хүнсний ногоо тариалахад аймгийнхаа хэрэгцээг бүрэн хангаж, үлдсэн хувьд нь малын тэжээлийн ургамал тариалах замаар мал аж ахуйгаа дэмжсэн газар тариаланг хөгжүүлэх бололцоотой.


### НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Баянхонгор аймгийн хүн амын дундаж насалтын үзүүлэлт

Аймгийн хүн амын дундаж насалт тогтмол нэмэгдэж байгаач бусад аймгуудтай харьцуулахад улсын хэмжээнд 17-р байранд байгаа нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дундаж насалт улсын дүнгээр /2014 оны статистик/




Баянхонгор аймаг хөгжлийн хэтийн зорилтсо тодорхойлохдоо хүний хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож байна. Хүний хөгжлийн түвшинг улс орнууд "хүн эрүүл байж урт наслах, мэдлэг, боловсрол эзэмших, амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх"

гэсэн хүний амьдралын үндсэн гурван нөхцлийг нэгтгэн ба таасан хүний хөгжлийн индекс гэсэн үзүүлэлтээр хэмждэг.


Баянхонгор аймаг 2014 оны хүний хөгжлийн индексээр улсын хэмжээнд 21 аймгаас 19-р байранд явж байна.

Хүний хөгжлийн индекс(2014 он)



Эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 21 аймгийн өрсөлдөх чадварыг харьцуулан судалсан "Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан"-г жил бүр гаргахдаа эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлэг, эдгээрийг нарийвчилсан 16 дэд бүлгийн хүрээнд 178 шалгуур үзүүлэлтийг харгалзан гаргадаг.

Баянхонгор аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлт



Баянхонгор аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлт тайлан гаргаж эхэлсэн анхны жилээс эхлээд жил дараалан өссөн хэдий ч улсын хэмжээнд хойгуур байранд байгаад анхаарлаа хандуулж хөгжлийн бодлогын үзэл санааг өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.



Өрсөлдөх чадварын тайлан (2014 он)



## 2.2. Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулах үндэслэл, эрх зүйн орчин

Дэлхийн улс орнууд эрчимтэй хөгжиж, даяарших үйл явц хурдацтай өрнөж, геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа энэ цаг үед Баянхонгор аймаг хөгжлийн бодлогоо эргэн харж, цаг үетэйгээ нийцүүлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай болсон.

Мөн аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулахад гадаад, дотоод хүчин зүйлүүд ч нөлөөлж байна.

### Гадаад хүчин зүйл:

Дэлхийн хүн төрөлхтний энх тайван амьдрах, эрх тэгш байх үндсэн зарчмуудыг сахиулахын төлөө ажилладаг дэлхийн 193 улс орныг эгнээндээ багтаасан НҮБ өнгөрөгч 2015 онд түүхт 70 жилийн ойгоо тэмдэглэж, энэ үеэрээ 2015-2030 он хүртэл дэлхий нийтэд баримтлан хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө батлан гаргалаа.

Мөн АНУ-Европ, ОХУ-Европгэсэнхоёр гол тэнхлэг-дэлхийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч байсан бол Украин улсад бий болсон нөхцөл байдлаас шалтаалан дэлхийн хөгжлийн цөм Ази тизрүү шилжиж Хятад, Орос гэсэн дэлхийн хоёр гүрний холбоо үүссэнээр геополитикийн шинэ нөхцөл байдал бий болсон нь Орос, Хятад гэсэн хоёр их гүрний дунд оршдог Монгол улсад ашигтай, таатай нөхцөл байдлыг бий болгоод байна.

### Дотоод хүчин зүйл:

Монгол Улсын Их Хурал 2015 оны 11-р сарын 26-ны өдөр Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийг баталсан.

Энэ хуулийг иш үндэс болгон УИХ-аас баталсан ажлын хэсэг "Монгол улсыг 2016-2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-ыг боловсруулж УИХ-аар батлуулсан.

Дээрх хүчин зүйлүүдийг иш үндэс болгон Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 02-р сарын 11-ны өдрийн 06 тоот тогтоолоор "Баянхонгор аймгийг дунд хугацаанд хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулж аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх ажлын хэсгийг байгуулсан билээ.

Энэ ажлын хэсэг НҮБ-ын 2015-2030 он хүртэл дэлхий нийтэд баримтлан хэрэгжүүлэх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон Монгол улсыг 2016-2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт болон 14 дүгээр зүйлийг иш үндэс болгон "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ыг боловсрууллаа.

Өнөөг хүртэл хүрсэн хөгжлийн үйл явцыг цаашид үргэлжлүүлэх, улам хурдтай хөгжихийн тулд аймгийн хэмжээнд баримтлах хөгжлийн дунд хугацааны бодлого шинэчлэн тодорхойлж байгаа нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн потенциалыг илүү оновчтойгоор бүрэн ашиглах, гадаад болон дотоод эрчин нөхцлийн өөрчлөлтөд нийцүүлэх, цаашдын ирээдүйн боломжийг нээлттэй байлгах нөхцөлийг бүрдүүлж байна.

Аймгийн хөгжлийн хэтийн зорилт нь монгол улсын хуулийн хүрээнд боловсрогдсон учир үндэсний, салбарын, орон нутгийн дунд, богино хугацааны хөгжлийн бодлогуудтай уялдуулж, нэгдсэн зорилгод чиглэгдэж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Баянхонгор аймгийн хөгжлийн хэтийн зорилт нь дэлхий нийтийн болон Монгол улсын хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн аймгийн онцлогт тохируулан тусгасан эдийн засаг, нийгмийн хөгжлийг ахисан түвшинд хүргэх, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, хүний хөгжлийг хангахад чиглэсэн болно.

### **2.3. Баянхонгор аймгийн хөгжлийн өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ ДАВУУ ТАЛУУД:**

#### **Байгалийн болон байршлын:**

- Хангай, говь, хээр тал хосолсон байгалийн гурзан бүсийн нутагтай
- Манай аймгийн нутгаар дэлхийн усан хагалбарын шугам болон нарны энергийн тусгалын төв дайрч өнгөрдөг, салхины эрчим хүчний нөөц ихтэй
- Түй, Байдраг, Цагаан туруут, Шаргалжуут зэрэг томоохон голууд, Орог, Бөөнцагаан, Хөх нуур, Биндэръяа Хөх нуур зэрэг нуурууд, Эхийн гол, Шар хулстай, Цагаан богд зэрэг эх говийн баян бүрдүүдтэй
- Эрдэс баялагын судалгаа харьцангуй сайн хийгдсэн, алт, нүүрс, давсны орд газруудтай

- Эмчилгээ, сувилгааны өндөр ач холбогдолтой Их, Бага Шаргалжуут, Өхөг, Тээл зэрэг халуун рашаанууд, Өргөөт, Ичээт, Хүрэмт, Халиут зэрэг хүйтэн рашаанууд, Үүд, Холбоолж зэрэг давсны болон шавар эмчилгээний ордуудтай
- Члхэр өөс, лидер, улаан, цагаан гоёо, зээргэнэ зэрэг эмийн ховор ургамлын нөөц сайтай
- Хангайн сумууддаа хар мод, бургас голлосон ойн бүс, говийн сумууддаа заг, тоорой, хайлаас сухай голлож ургасан ойн бүсүүдтэй
- Хавтгай, Хулан, Аргал, Янгир, Хар сүүлт, Мазаалай зэрэг улаан номд орж дархлагдсан ховор ан амьтай ихтэй
- Дэлхийд анхны хүн амьдарч байсан өлгий нутаг Лигийн Цагаан агуй, аварга биет үлэг гүрвэлийн чулуужсан ясны олдвор ихтэй Бугийн хоолой, Эзэн Богд Чингэс хяаны байлдаж байсан болон хожмос Монголын хаад, ноёд цуглан "Их хуралдай" хуралдуулж эх орныхоо хувь заяатай холбоотой амин чухал асуудлыг хэлэлцэж байсан түүх домогт Заг, Байдрагийн Хүрэн бэлчир, дэлхийд анх шатар үүссэнийг нотлох түүхийн ховор дурсгалт газар болох Шатар чулуу зэрэг түүх соёлын дурсгалт газруудтай
- Баруун аймгуудыг нийслэл Улаанбаатартай холбосон замын гол дунд байрладаг
- Баянхонгор аймаг бүрэлдэхүүнд нь багтдаг Хангай бүсийн аймгуудын БНХАУ-тай хиллэдэг ганц аймаг
- Ази, европыг холбосон босоо тэнхэлгийн авто зам Баянхонгор аймгаар дайран өнгөрөх хэтийн төлөвтэй.

#### **Эдийн засгийн:**

- Монгол улсын хэмжээнд нийт малын тоогоор эхний 5-д, ямааны тоогээр 1-д, тэмээний тоогоороо 2-д тус тус ордог
- Монгол улсын хэмжээнд хамгийн их ноолуур үйлдвэрлэдэг аймаг бөгөөд тэр дотроо сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг цагаан ноолуураараа алдартай.
- Ямаа ихтэй говийн бүсийн сумууд нь ямааны сүүгээр уламжлалт цагаан идээ бэлтгэдэг арга туршлага сайтай. Бууцагаан, Богд, Баацагаан сумдын малчдын бэлтгэдэг говийн бор ааруул нь Монгол улсдаа алдартай
- Баянхонгор аймгийн эдийн засгийн голлох салбар нь МАА учир малаас гардаг түүхий эд бүтээгдэхүүнийхээ нөөцөөр улсдаа дээгүүр ордог

#### **Нийгмийн салбар ба хүний хөгжлийн:**

- Хүн ам өсч, хөдөлмөрийн наснь хүн ам нэмэгдэж байгаа
- Хүн амын суврагын бүтэц эерэг хандлагатай болж, хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаа
- Дээд боловсролтэй хүний тоо нийт хүн амын 8.4 хувь байгаа

- Зөхион байгуулалт, удирдлагын оновчтой менежментийг хэрэгжүүлэн Байдрагийн голоос суваг татаж Хэрсэнгийн талыг усжуулан тэжээлийн ургамал тариалж, Адгийн цагаанд тэжээлийн үйлдвэр байгуулж байсан, Цагаан даваа болон Тонгорын алдартай даваануудыг засч хадлан, бэлчээрийн шинэ нөөцийг бий болгож ашиглаж байсан зэрэг хөдөлмөрч уламжлалтай
- Монголын анагаах ухааны салбарын анхны сточ маарамба, одон зурхайн шинжлэх ухааныг анх үүсгэн байгуулж анхны бүтээл туурвилыг бүтээсэн, Монголын шашны 3 зулын нэг Ламын гэгээн Лувсанданзанжанцан, Монголын хөгжмийн зохиолчдын ноён оргилууд Гончигсумлаа, Бирваа, Сангидорж, хэл шинжлэлийн ухааны нэрт эрдэмтэн Ш.Лувсанвандан, С.Лувсанвандан, Монголын нэрт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэн, Т.Галсан, төрийн шагналт, гавъяат жүжигчин Д.Сосорбарам зэрэг алдар цуутнуудыг төрүүлсэн гайхамшигтай генитэй

#### **Дэд бүтцийн:**

- Бүх сумын төвүүд төвийн эрчим хүчний системд холбогдсон
- Нийслэлтэй хатуу хүчилтэй замаар холбогдсон, Монгол улсын ази, европыг холбосон хэвтээ тэнхэлгийн хатуу хүчилтэй авто зам дайран өнгөрдөг, тээвэр логистик, транзитийн хувьд сайн байршилтай
- Аймгийн бүх сум үүрэн телефоны сүлжээнд холбогдож, хөдөөгийн иргэдийн ... хувь нь орон зайн хамааралгүйгээр дотоод болон гадаад улс орнуудруу чөлөөтэй харилцах бололцоотой болсны зэрэгцээ аймгийн 18 сум өндөр хурдны шилэн кабелиар холбогдсон.

#### **СУЛ ТАЛУУД:**

##### **Байгалийн болон байршлын:**

- Бэлчээрийн даад хэтэрч, элсний нүүдэл ихсэн гол горхи, нуур цөөрөм, булаг шанд, богино гүнтэй энгийн уурхай худгууд хуурайшиж целжилтийн явц хурдасч байгаа, экосистемийн эмзэг орчинтой,
- Аймгийн хүн амын унданд ашиглаж байгаа нийт уст цэгийн 44 хувь нь хүн амын ундны усанд тохиромж муутай хатуулаг ихтэй ус байдаг
- Байгалийн баялаг ихтэй учир иргэд гар аргаар алт олборлон, байгаль дэлхийгээ сүйтгэх нь ихэссэн
- Тал хээр говийн бүс нь хөндий, тал хоолойнууд ихтэй учир хүчтэй шалхи шуурга их болдог
- Сумуудын 50 шахам хувь нь төвөөсөө 200 км-ээс цааш алслагдсан, хүн ам тархай бутархай байршилтай
- Түүх, соёлын өвийн хамгаалалт сул

#### **Эдийн засгийн:**

- Ихэнх сумууд нь аймгийн төвөөсөө буюу томоохон зах зээлээсээ хэт алслагдсан байршилтай учир хөдөөгийн иргэд мах, сүү, цагаан идээгээ зах зээлд тэр болгон борлуулаад байх болсмж муутай учир бүх малаа эдийн засгийн эргэлтэнд оруулж чаддаггүй
- Өндөр ашиг шимтэй мал сүрэг, эрчимжсэн аж ахуй хөгжөөгүй
- Байгаль цаг агаарын эрс тэс уур амьсгалтай учир мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл цаг уурын өөрчлөлтөөс хэт хамааралтай;
- Жижиг, дунд үйлдвэрлэл сул хөгжсөн учир бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараар зах зээлд өрсөлдөх чадвар сул, нийслэл Улаанбаатараас алслагдсан, тээврийн зардал ертөг харьцангуй өндөр,
- Аймгийн дотоод зах зээлийн багтаамж бага, нийслэл хотын болон төвийн бүсийн томоохон зах зээлээс алслагдсан
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зохион байгуулалт, хамтын ажиллагаа сул, малчид хөдөлмөрөө хоршиж ажиллах сонирхол багатай
- Эдийн засгийн голлох салбар нь МАА-н үйлдвэрлэл боловч, энэ салбарлуугаа малчид болон төрөөс хөрөнгө оруулалт муу хийдэг
- Эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур байгаатай холбоотойгоор аймгийн татварын орлого бага, аймгийн төсөвт улсын татаас голлох үүрэгтэй, өрсөлдөх чадварын үзүүлэлтээр улсын хэмжээнд хойгуур ордог
- Ургамлын гарц муу, хур бороо багассанаас малчид хадлан, тэжээл бэлтгэх бололцоо хомс, хөрсний үржил шим тааруу учир газар тариалан сул хөгжсөн.

#### **Нийгмийн салбар ба хүний хөгжлийн:**

- Хүн амын тоо цөөн, өсөлт удаан, тархай бутархай байршилтай, ажилгүйдэл ядуурлын түвшин өндөр, шилжилт хөдөлгөөн ихтэй, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо харьцангуй их
- Хөдөөгийн иргэд төв суурин газарлуу тэмүүлэх нь ихэссэн учир төв суурингийн ачаалал ихсэж, амжиргааны гол хэрэгсэл болсон МАА-н салбарт ажиллагсад цөөрөх, хэгшрөх хандлагатай болсон
- Мэргэжлийн ур чадвар сайтай инженер техникийн ажилтан, ажилчид, зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтний тоо цөөн, МСҮТ-ийн сургалтын чанар тааруу байгаагаас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжрахгүй байгаа
- Говийн бүс нутгийн ундны усны хатуулаг ихтэй учир хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл ихтэй байгаагийн зэрэгцээ хөдөөгийн хүн амд хүрч үйлчлэх эмнэлгийн үйлчилгээ сул байгаагаас нярай хүүхдийн болон эхийн эндэгдэл, халдварт өвчнөөр өвчлөгсдийн түвшин харьцангуй өндөр байна

- Хүний хөгжлийн индексээр улсын хэмжээнд хойгуур байгаа үзүүлэлт сайжрахгүй байна.
- Боловсролын чанар тааруу, гэр бүлийн хүмүүжлийн соёл алдагдаж, хүүхдэд цэцэрлэгийн наснаас нь эхэлж хөдөлмөрийн хүмүүжлийг төлөвшүүлж үндэснийхээ уламжлалт соёл, ах захаа хүндэлдэг заншил, эд хөрөнгийг биш эрдмийг эрхэм болгодог ёс зүйд сургадаг байсан арга ухаан мартагдсанаас хүн амын олонхи болсон хүүхэд, залуучуудын ёс суртахууны хүмүүжилдоогуур, залхуурах, биеийн амрыг харах, бэлэнчлэх сэтгэлгээ, зугаа цэнгэлд хэт автсан залуучуудын тоо буурахгүй байна
- Аймаг орон нутагт улс төржилт их, ах дүү найз нөхөд, нам эвслээрээ талцдаг, төрийн ажилтнуудын тогтвор сууршил хангалтгүй, төрийн байгууллагууд, төрийн ажилтнуудын хүнд суртал их, сахилга хариуцлага сул, туршлага, ур чадварын дутагдалтай байдал нь аймаг орон нутгийн хөгжилд чөдөр тушаа болж байгаа

#### **Дэд бүтцийн:**

- Нэгдсэн халаалтын системгүй учир олон жижиг уурын зуухтай, агаарын бохирдол их
- Ихэнх сумдын сургууль, эмнэлэг, цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээний барилга байгууламж хуучирч муудсан
- Мэдээлэл харилцааны технологи хөгжөөгүй
- Зам, харилцаа болон аялал жуулчлалын дэд бүтэц хөгжөөгүйгээс дотоод, гадаадын аялагчид, жуулчдыг татах боломж бага
- Сумуудад инженерийн шугам сүлжээ хөгжөөгүй

#### **БОЛОМЖ:**

- Хойд, урд хоёр хөрштэй байгуулсан стратегийн түншлэлийн боломжуудыг чадварлагаар ашиглаж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бололцоог бүрдүүлэх
- Японы Ойта муж болон Саппоро хотууд, БНХАУ-ын Альшаа аймагтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, хэлцлүүдийг идэвхтэй ашиглаж хөгжлийн шинэ боломжуудыг нээх
- Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз авсан аж ахуйн нэгжүүдтэй харилцан ашигтай хамтран ажиллах зарчмыг удирдлага болгож, санаачлагтай ажиллан тэднийг аймгийн эдийн засгийн хөгжилд татан оролцуулах
- Баруун аймгууд болон нийслэлийг холбосон хатуу хучилттай авто зам аймгийн нутгаар дайран өнгөрдөг давуу талаа түшиглэн замын дагуу онсвчтэй байршлуудыг тодорхойлж, үйлчилгээний төвүүд болон сууршлын бүсүүдийг бодлоготойгоор хөгжүүлэх,

- Үүрэн телефоны операторуудтай хамтран ажиллаж аймгийнхаа бүх нутаг дэвсгэрт сүлжээтэй болох
- Өндөр хурдын шилэн кабелийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар бизнесийн шинэ боломжуудыг орон нутагт бий болгох, зах зээлийн мэдээллийн орон зайн зааг ялгааг арилгах, мэдээллийн хурдыг сайжруулах
- Хангай бүсийн болон хил залгаа Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл зэрэг аялал жуулчлал хөгжсөн аймгуудын аялалын маршруттай холбогдох замаар аялал жуулчлалын шинэ маршрутыг нээх
- Говийн бүс нутагт үйлдвэрлэсэн Хангайн аймгуудад нэн шаардлагатай байдаг бараа бүтээгдэхүүн, Хангайн бүс нутагт үйлдвэрлэсэн говийн иргэдэд нэн хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүний арилжаа, худалдааг хөгжүүлэх

#### **ЭРСДЭЛ:**

- МАА-н түүхий эд бүтээгдэхүүний голлох зах зээл болох Хятад улсын зах зээлийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн өсөлт, бууралтаас нь хамаарч МАА-түүхий эд бүтээгдэхүүний үнэ унах
- Байгаль орчинд гарч байгаа өөрчлөлт, зуд, ган гачиг зэргээс хамаарч Монгол улсын газар тариалангийн бүс нутгуудад ургац алдвал гурилын үнэ өсөх
- Манай улсад нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэгч гол улс болох ОХУ-ын бодлогоос хамаарч шатахууны үнэ нэмэгдэх
- Монголчуудын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний гол нийлүүлэгч БНХАУ-ын эдийн засгийн бодлогоос шалтгаалан импортын гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх
- Малын гсц халдварт өвчнөөс хамаарч экспортын боломж алдагдах
- Ган, зуд, хүчтэй цасан болон шороон шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдлээс хамаарч аймгийн эдийн засагт хохирол учирч, иргэдийн амжиргааны түвшин буурч ахилгүйдэл, ядуурал нэмэгдэх
- ОХУ-аас эрчим хүчний дотоод хэрэглээ, болзошгүй хүчин зүйлүүдээс хамааралтайгаар импортоор авдаг цахилгааны үнэ нэмэгдэх


#### **2.4. Аймгийн эдийн засгийн нөөц, боломж**

##### **2.4.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР:**


Нөөц, үйлдвэрлэлийн хувьд аймгийн эдийн засгийн голлох салбаруудаас аймгийн хэмжээнд өнөөгийн байдлаар ХАА-н салбар тэргүүлж, аймгийн нийт ажиллагсадын 66,1 хувь нь ХАА-н салбарт ажиллаж, аймагт үйлдвэрлэсэн нийт ДНБ-ний 53,1 хувийг ХАА-н салбарт үйлдвэрлэж байна.

Баянхонгор аймаг 2014 онд 3 565 900 толгой мал тоолуулж нийт малынхаа тоогоор улсын хэмжээнд хамгийн олон малтай эхний 5 аймгийн тоонд, хангай бүсдээ дөрөвт, хил залгаа аймгуудын хэмжээнд гуравт орж байна.

Хангайн бүсийн аймгуудын нийт малын тоо (2012-2014 он)



Хил залгаа аймгуудын нийт малын тоо (2012-2014 он)



Баянхонгор аймгийн 2014 оны малын тоог жишиг болог авч үзвэл жилд дунджаар 748,3тн ноолуур, 208,3тн тэмээний ноос, 1186,8тн хонины ноос, 68,3тн сарлагын хөөвөр, 12070,3тн мах нийт хээлтэгч малын 50 хувийг саалинд ашиглана гэж тооцоход 41,075,950л сүү, 17852ш үхрийн шир, 2351ш тэмээний шир, 7705ш адууны шир, 242113ш ямааны арьс, 131135ш хонины нэхийг тус тус бэлтгэж зах зээлд нийлүүлэх бололцоотой байна.

Эдгээр түүхий эдийг зах зээлийн өнөөгийн ханшаар тооцоход Баянхонгор аймаг зөвхөн МАА-н түүхий эдээсээ жил бүр 230,0 тэрбум тэгрөг босгох бололцоотой нь харагдаж байна. Энэ нь манай аймгийн 4 жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний мөнгө юм.

Дээрх судалгаанаас үзэхэд манай аймгийн малчид нийт мал сүргийнхээ 10 срчимхувийг жилддунджаар эдийн засгийн эргэлтэнд оруулж байна.

Эрдэмтдийн тооцоо судалгаагаар малчин өрхүүд нийт мал сүргийнхээ 20-25 хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэнд оруулаад байхад хамгийн тохиромжтэй гэж үздэг. Энэ



тооцоог иш үндсэн болгож аймгийн нийт мал сүргийнхээ 20 хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэнд оруулж байхаар тооцоход жилд дунджаар 748,3тн нослуур, 208,3тн тэмээний ноос, 1186,8тн хонины ноос, 68,3тн сарлагын хөөвөр (малаа ноосолсны дараа борлуулахаар тооцов), 20856,7тн мах, нийт хээлтэгч малын 50 хувийг саалинд ашиглана гэж тооцоход 41,075.950л сүү, 34153ш үхрийн шир, 8333ш тэмээний шир, 25262ш адууны шир, 427620ш ямааны арьс, 197803ш хонины нэхийг тус тус бэлтгэн зах зээлд нийлүүлж, 280,0 тэрбум төгрөгийн борлуулалтыг жил бүр малынхаа ашиг шимээс хүртэх боломжтой нь харагдаж байна. Энэ орлогыг нийт малчин өрхийн тоонд хуваавал нэг малчин эрхэд 26,4 сая төгрөг ногдож байна.

Манайд бэлтгэж буй махны 25-30 хувийг үхрийн, 35-40 хувийг хонины, 10-15 хувийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлдэг ба гахай, тахианы махны үйлдвэрлэл хөгжөөгч. Иймээс мал сүргийн бүтцэд экспортын илүү их хэрэгцээтэй үхэр, адууны мах бэлтгэл бага байгааг анхаарч цаашид махны чиглэлийн үхэр, адуу, гахай, тахианы тоо толгойг эсгөж махны нөөцийг нэмэгдүүлэх бсдлогыг баримтлах нь зүйтэй юм.

Баянхонгор аймаг 2010 онд нийт 413,0 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо тариалж 3649,2 тн ургац хураан авч байсан бол 2014 онд 402,1 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо тариалж 4687,8 тн ургац хураан авсан байна.

Хэдийгээр 1 га-гаас хураан авах ургацын хэмжээ нэмэгдсэн хэдий ч 2014 оны байдлаар аймгийнхаа хүнсний ногооны хэрэгцээний 34,0 хувь, төмсний хэрэгцээний 62,0 хувийг хангаж байна.

Баянхонгор аймагт 1060 га тагбай бүхий 17 инженерийн хийцийн услалтын систем байдаг ба 2015 оны байдлаар 472 га талбай бүхий 9 услалтын системд иж бүрэн засвар үйлчилгээг хийж, 2016 оны төсөвт Бумбатын амны 96 га талбай бүхий услалтын системд засвар үйлчилгээ хийх зураг төсвийн үнийг аймгийн ИТХ-аас шийдвэрлэсэн.

*Баянхонгор аймагт ашиглагдаж байгаа инженерийн хийцтэй услалтын системүүд*

№	Сумын нэр	Услалтын системийн нэр	Талбайн хэмжээ /га/	Засвар хийгдсэн байдал	Ашиглаж байгаа талбай /га/	Тариалж байгаа ургацын нэр, төрөл
1	Өлзийт	Бумбат	96	үгүй	40	Төмс, хүнсний ногоо
2	Өлзийт	Бор балгас	97	үгүй	36	Төмс, тэжээлийн ургамал
3	Өлзийт	Шаргалжуут	86	үгүй	13	Төмс, чацаргана
4	Өлзийт	Эрдэнийн хөндий	25	үгүй	25	Тэжээлийн олон наст ургамал
5	Баянлиг	Лигийн гол	60	2013 онд засварласан	15	Төмс, хүнсний ногоо
6	Баянговь	Цагаан гол	60	2015 онд засварласан	0	2015 онд засвар дууссан
7	Шинэжинст	Эхийн гол	20	2013 онд засварласан	15	Улаан лойл, өргөст хэмх, эрдэнэ шиш
8	Баянцагаан	Цагдуулт	60	2013 онд засварласан	57	Төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал
9	Бөмбөгөр	Хунзат	80	2015 онд засварласан	0	2015 онд засвар дууссан
10	Бууцагаан	Баян	28	2014 онд засварласан	28	Тэжээлийн ургамал

11	Бууцагаан	Өлзийт гол	58	2014 онд засварласан	40	Төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал
12	Галуут	Тальн толгой	60	2013 онд засварласан	60	Төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал
13	Баян-Овоо	Хоолт	46	2008 онд засварласан	46	Төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал
14	Баацагаан	Хөх эрэг	52	үгүй	0	Тариалалт хийгээгүй
15	Заг	Сайхан тохой	124	зураг хийгдсэн	50	Чацаргана, төмс, хүнсний ногоо
16	Бөмбөгөр	Бор толгой	88	зураг хийгдсэн	0	Тариалалт хийгээгүй
17	Бөмбөгөр	Хотын булан	20	зураг хийгдсэн	0	Тариалалт хийгээгүй

Баянхонгор аймаг 2014 онд 3908.5 тн хадлан бэлтгэсэн нь хонин толгойд шилжүүлсэн нэг малд дөнгөж 0.7 кг ногдож байгаа нь дэлхий даяар хуурайшилт, дулаарал эрчимтэй явагдаж байгаль цаг агаараас учрах эрсдэл ихсэж байгаа энэ үед мал сүргээ эрсдэлээс хамгаалах боломж муутайг харуулж байна.

Иймээс өрх бүр өрхийн тариалан эрхлэж, дээрх услалтын системүүдийн нийт талбайн 40 хүртэл хувьд дэвшилтэд технологээр хүнсний ногоо тариалж, үлдсэн хувьд нь малын тэжээлийн ургамал тариалахад аймгийнхаа хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангаж, малын тэжээлийн тодорхой хэмжээний нөөцийг бүрдүүлэх боломж байгааг ашиглах шаардлагатай байна.

Баянхонгор аймаг газар тариалангийн үйлдвэрлэлээ кластерийн зохион байгуулалтаар хөгжүүлэх бодлогыг баримталж мал аж ахуйгаа дэмжсэн газар тариаланг хөгжүүлснээр аймгийнхаа эдийн засгийн голлох салбар болсон мал аж ахуйгаас олох ашиг шимээ нэмэгдүүлэн иргэдээ ядуурлаас гаргаж, эдийн засгийн хувьд өрсөлдөх чадвартай аймаг болох бүрэн боломжтой юм.

#### **2.4.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР:**

Баянхонгор аймаг нь Төв Азийн өндөрлөгт, Сибирийн их тайгаас Төв Азийн говь цөлд шилжих шилжилтийн ландшафт бүхий байгалийн олон янзын бүс бүслүүр буюу хангай, тал хээр, говийн үзэсгэлэнт байгалийг хамран оршиж байгаа нь аялал жуулчлалын слон төрөл хэлбэрийг хөгжүүлэх давуу талыг бий болгосон. Иймээс Монгол оронд байгалийн аялал хийхээр ирсэн жуулчид нь зөвхөн Баянхонгор аймгаар аялахад Монголын байгалийн гурван өөр бүс, нүүдэлчдийн амьдралын гурван өөр хэв шинж, соёл, өвөрмөц онцлогыг үзэж сонирхох ховорхон боломжийг олно.

Баянхонгор аймгаас өөр хаана ч давтагдашгүй, аялал жуулчлалын онц сонирхолтой, үнэ цэнтэй нөөцүүд "Говь-хангайн цэнхэр орон" хэмээн алдаршсан Хонгор нутагт л бий.

Тухайлбал, энэ дэлхий дээрх хамгийн эртний хүмүүс амьдарч байсныг нотолсон Цагаан агуй, өөр гариг ертөнцийн оюун ухаантнуудын бүтээл байж болох юм гэж зарим судлаачид тодорхойлдог Цагаан булагийн хадны дүрс зургууд, эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох Бичигтийн хөндийн хадны сүг зургууд бүхий байгалийн галарей, байгалийн өвөрмөц сонин тогтоцтой, анагаах эдгээх чадвараараа хосгүй 96 хэмийн халуун Шаргалжуутын халуун рашаан, одоогоос 100-200 сая жилийн тэртээ амьдарч байсан аварга биет диназаворын чулуужсан яс бүхий Бүгийн

цав, энэ дэлхий дээр анх Монгол нутагт шатар үүссэнийг гэрчлэх Шатар чулууны хөшөө дурсгал, дэлхий дээр зөвхөн Баянхонгорын нутаг цөөн тооны байдаг говийн баавгай хэмээх "Мазаалай" гэх мэт гайхамшгуудыг нэрлэж болох юм.

### **Баянхонгор аймгийн аялал жуулчлалын хаана ч давтагдашгүй нөөцүүд**

#### **Цагаан агуй**

Монгол улс, тэр тусмаа Баянхонгор аймаг нь хүн үүссэн өлгий нутаг болохыг гадаадын олон орны эрдэмтэд нотолсоор ирсэн. Тухайлбал, 1989 онд Баянхонгор аймгийн "Уранхайрхан" гэдэг газраас олдсон архелогийн олдвор нь одоогоос 500 000 жилийн өмнө манай дэлхий дээр анх хүн үүссэнийг нотлох үнэ цэнэтэй олдвор байсан бол 1996 онд Америк, Орос, Монголын эрдэмтдийн хамтарсан экспедицийн Цагаан агуйгаас олдсон олдвор нь дэлхий дээр одоогоос 750 000 жилийн тэртээ хүн амьдарч байсныг нотолжээ. Энэ олдвор нь одоогоор энэ дэлхий дээр олддоо байгаа олдворуудаас хамгийн эртнийх нь. Иймээс Баянхонгор аймаг нь хүн төрөлхтний өвөг дээдсийн өлгий нутаг юм.



#### **Хүрэн бэлчир**

Монголын нууц товчооны 159,161-р зүйлд "...Чингэс хаан Ван хан хоёрыг буцаж явахад Найманы Хадгалдач Хөгсээ Сабраг "Байдрагийн бэлчирт" цэрэг засаж тулалдахаар зэхэж байсан ажгуу. Чингэс хаан Ван хан хоёр хатгалдъя хэмээн цэрэг засаж



хүрч (ирээд) орой боллоо маргааш хатгалдъя хэмээн зэрэгцэн хонов. Тэгээд Ван хан буйран дээрээ гал түлж орхиод шөнө Хар сүүл (гслын нэр) өөд өгсөн явжээ" гэж тэмдэглэсэн байдаг.

Хожим түүхийн энэ дурсгалт газар Манжийн Энх-Амгалан хааны 25 дугаар оны /1686 он/ улаан бар жилийн намар Заг, Байдрагийн Хүрэн бэлчирт Монголын хаад ноёд, төрийн зүтгэлтнүүд цугларч Улсын Их Хуралдайг хуралдуулан Монгол улсын

хувь заяатай хслбоотой амин чухал асуудлуудыг хэлэлцэж байсан түүхтэй.

#### **Шатар чулуу**

Эдэнэцогт сумын нутагт байдаг "Шатарчулуу"-ны хөшөө дурсгал нь манай эриний өмнөх 3000 жилийн тэртээх эртний хүмүүсийн оюуны соёлын гайхамшигт өв юм.



Шатар чулуунь тухай түүхийн нэн сонин домог байдаг. Энэ нь Монгол овогтны нэгэн том шатарчин хааныг нас барахад энэ газар оршуулж түүний дурсгалыг мөнхлөн шатар чулууны хөшөө дурсгалыг босгосон гэж ам дамжин ярьж иржээ. Энэ домгийг нотлох сүг зураг сийлбэр бүхий дөрвөлжин хашлагатай оршуулга, Монгол шатрын дүрс хэлбэрүүд болох янз




бүрийн амьтны чулуун сийлбэрүүд байдаг.

МЭ 450-550 жилийн үед Хүннү нар шатар тоглодог байсныг Английн эрдэмтэн Г.Мэрэй Шатрын товч түүх номондоо тэмдэглэснээс үзвэл. Монгол овогтноос анх шатар үүсч хөгжсөн гэсэн дүгнэлт хийж болох юм.

### Бүгийн цав

Бүгийн цавийн хоолойд зочлох үед өөр гараг ертөнцөд хөл тавьсан мэт сэтгэгдэл төрж, одоогоос 150 гаруй сая жилийн тэртээх амьдрал төсөөлөгддөг. Тэнд ертөнцийн гайхамшиг хэмээгдэх 50-иас 80 тонн жинтэй, 20 шахам метр урт, 3-4 метр өндөр аварга гүрвэлүүдийн чулуужиж хоцорсон яс, дун хясаа зэрэг цэнгэг усны амьтадын чулуужсан яс, далайн ёроол байсныг илтгэх шавар хэрмэн цавуудыг үзсэнээр монголын говь нутаг нь 200-100 сая жилийн тэртээ гадагшаа урсгалгүй цэнгэг усны ай сав газар байсныг мэдэх болно.



Энэ аварга амьтныг ертөнцийн гайхамшиг болохын нь хувьд нэгэн баримт дурдъя. Дэлхийн аваргуудын тухай алдарт Гиннесийн номд, эдүгээ тодорхой мэдээгээр үзэх үл дэлхийн хамгийн урт сарвуут амьтан бол Цэрдийн галавын үед Монголын говьд амьдарч байсан Теризинозавр хэмээх үлэг гүрвэл юм. Түүний сарвууны урт 91,4 см юм гэжээ.

Эртний энэ аварга амьтад болон далайн амьтадын чулуужсан яс нь Бүгийн хоолой төдийгүй


Шинэжи-ст сумын Ногоонцав, Богд сумын Орог-уурын орчин, Амгол, Луу яст зэрэг газруудаас олддог.

### Гүр дууны нот "ЯН-ИГ"

Чин сүзэгт Номунхан (одоогийн Баянхонгор аймгийн Гагуут сумын Мандалын хийд) Лувсанноровшийравын удаа дараагийн дүр хувилгаадын зохиосон "Гүр дууны бичиг" хөгжмийн бүтээл нь 18-р зууны томоохон туурвилын нэг юм.

Гүр гэдэг нь эртний Энэтхэг, Төвдийн утга соёлын зүйлээс дамжин ирж, Монголчуудын шашны зан үйл, түүний дотор сүм хийдийн найрын дуу хөгжмийн төрөл үлэмж дэлгээсэн нэгэн зүйл дууны төрөл юм. Гүр дууны нотыг "Ян-иг" гэдэг.


Гүр дууны нот буюу "Ян-иг"-ийг Чин сүзэгт Номунханы 1,2,3-р дүрүүд болох анхдугаар хувилгаан Лувсаншийрав /1701-1768/, 2-р хувилгаан Лувсандандарванчиг /1760-1827/, 3-р хувилгаан Бадамдорж /1830-1882/ нар зохиосон байна. Урлагын энэ ховор нандин үзмэр зөвхөн Баянхонгор аймгийн музейд л байдаг.



хонхойлтон мөлгөр гадаргуутай болгосон болов

### Цагаан булаг

"Цагаан булаг" –ын хадны дүрс зургууд нь хүүхдийн сэдвээс бүрдсэн зургуудын цогцолбор дурсгал мөн. Энд хүүхэд гулгасаар байгаад хадыг



уу гэмээр гулсуур хад, 3-4 настай хүүхэд хадыг хонхойлгон /хэв гарган/ гишгээд явсан гутлын мөр, хадан дээр хэв гарган бүтээсэн хэвтэж байгаа хүүхдийн дүрс зэрэг олон зургууд байдаг. Уг хүүхдийн зургийн онцлог нь гарын дунд хуруунууд нь бусад хуруунуудаасаа хоёр дахин урт бөгөөд үзүүр дээрээ том товгортой, толгой дээрээ цагираг хэлбэрийн антен боловуу гэмээр дүрстэй, чих нь урт нарийн, хөл нь майг бөгөөд богинохон, ахар сүүл нь урт дүрс байдаг.

Мөн морины дүрс ч бий. Түүний хажуу талын хадан дээр хар өнгөөр бичсэн дүрс үсгийн бичээсүүд байдаг.

Түүх соёлын хосгүй нандин энэ дурсгалыг судалж байгаа зарим эрдэмтэд эдгээр дурсгалыг өөр гариг ертөнцийн оюун ухаантны бүтээл байж болох юм гэж үзсэн нь бий.

### **Бичигт хад**



Баянгийн нурууны Их Бичиггийн аманд эдүгээгээс 3000 жилийн тэртээд холбогдох эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болсх сүг зургууд бүхий байгалийн галарей бий. Энд сонирхол татсан нэгэн зураг бол анжисанд үхэр хөллөөд газар хагалж буй хүнийг дүрсэлсэн зураг.

Энэ зургийг МЭӨ-III мянган жилийн өмнөх үеийн бүтээл гэж үздэг.

Үүнээс үзэхэд энэ нутагт оршин суугчид 3000 жилийн өмнө малын хүчийг тэргэнд хөллөн ашиглаж газар тариалан эрхлэж байсны нотолгоо юм. Иймээс энэ зураг нь Дэлхий дээр хамгийн анх түрүүн тэрэг бүтээсэн ард түмний нэг нь Монгол гэдгийг харуулж байгаагийн илэрхийлэл гэж нэгэн судлаач хэлсэн байдаг.

### **Говийн үзэсгэлэнт байгаль**



Баянхонгор аймгийн говийн үзэсгэлэнт байгаль нь аймгийн төвөөсөө 150 км-т орших их говийн элсэн манхан, заган шугуйд шургалан тогтсон Монголын говийн хамгийн том нуурууд болох Бөөнцагаан болон Орог нуур, Монголын хоолсйгоос эхлэн эх орны баруун хязгаар буюу Монгол

улсын торгон хил хүртэл сунаан тогтсон өргөн уудам нутгийг хамарна.

Их говийн чимэг болсон Орог, Бөөнцагаан нууруудын эргэн тойрон дахь их говийн элсэн манхнууд болон говь нутгийн чимэг болсон заганшугуйд, дэлхийд ховордсон хоёр бөхт тэмээн сүрэг бэлчиж, нүүдлийн соёл иргэншлийн томоохон төлөөлөгч болсон төв халхын малчин ардууд ажиллаж амьдарч байдаг нь гадаадын аялагчдын сонирхлыг ирэхгүй татдаг билээ.

Орог нуурын хаяанаас дэлхийн хамгийн эртний хүн амьдарч байсан буурь сууц олдож байсны зэрэгцээ түүх соёлын нандин өв болох олонзуун хиргэс үүр, булш бунханууд нуурынзүүн хаяагаар ярайн байдаг.

Баянхонгорын говь нутаг нь энэ дэлхийн анхны хүн амьдарч байсан буурал түүхийн гэрч болохын зэрэгцээ аварга биет үлэг гүрвэлийн чулуужсан яс, түүний амьдарч байсан үл мөр болон дун хясаа зэрэг цэнгэг усны амьтадын чулуужсан яс, далайн ёроол байсныг илтгэх шавар хэрмэн цавууд нь Баянхонгорын говь нутаг нь 200-100 сая жилийн тэртээ гадагшаа урсгалгүй цэнгэг усны ай сав газар байсныг илтгэх болно.

### Мазаалай

Дэлхий дээр 20 гаруйхан тоотой үлдсэн говийн баавгай хэмээх Мазаалай нь зөвхөн Баянхонгорын говийн бүс нутагт л байдаг.

Тэрчлэн Баянхонгор аймагт дэлхийн "Улаан ном"-д орсон хулан, хавтгай, ирвэс Монгол улсын "Улаан ном"-д орсон эрээн хүрэн, цоохондой, хар сүүлт зээр, аргал, янгир, жороо тоодог зэрэг ховор ховордсон амьтад элбэг.



### Шаргалжуутын рашаан



Шаргалжуутын халуун рашаан нь далайн түвшнээс дээш 1492 метр өндөрт Шаргалжуут голын дэргэд байрладаг. Энэ гайхамшигт рашаан нь 108 төрлийг өвчнийг анагаах чадвартай, 108 төрлийн халуун, хүйтэн рашаануудаас бүрддэг. Эдгээрийн хамгийн халуун нь нэмэх 96 хэмийн халуун байдаг.

Шаргалжуутын халуун рашаан нь байгалийн өвөрмөц сонин тогтоц, анагаах эмчлэх чадвараараа дэлхийд хосгүй рашааны нэгэнд тооцогддог.

Шаргалжуутын рашаан бүр нь хүний бие эрхтнүүдийн байгалаас урлан бүтээсэн хэлбэр дүрс бүхий хад, чулуунаас ундрэн гардаг. Тухайлбал, хоолой өвчнийг анагаах рашаангэхэд хүний хоолойн хэлбэр дүрстэй хаднаас, шүдний рашаан гэхэд шүдний хэлбэр дүрс бүхий хаднаас оргилон гарч байдаг нь байгалийн сонин хачингайхамшгийн нэг юм.

### Их Богд уул

Говь-Алтайн нурууны ноён оргилуудын нэг, мөнх цаст Их Богд уул нь далайн түвшнээс дээш 3957 метр өргөгдсөн, Монголын их говьд орших атлаа хангайн байгалийг санагдуулам номин ногоон хөвд ургамал, өнгө агаглах цэцэгсийн хүрээлэн, хүрхрэн шуугих өндөр уулын түргэн урсгалт гол горхи, газар хөдлөлтөөс тогтсон байгалийн өвөрмөц сонин тогтоц, нуур, дэлхийд ховордож дархлагдсан аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтад, вансэмбэрүү, алтангагнуур, лидэр зэрэг эмийн ургамлуудыг үзэж болох юм.




Их Богд уулын оргилд зуны дунд сард цас будран орж байхад уулын дунд хэсэгт бороо орж, бэл хоолойд нь 20-30 хэмийн халуун байдаг олон бичил уур амьсгалтай нутаг юм.

Их Богд ууланд 1957 онд хүчтэй газар хөдлөлт болж уулын нэгэн оргил тасран унаж хоёр голын хөндийг хааснаар эдүгээ "Хөх нуур", "Ногоон нуур" нэртэй үзэсгэлэнт хоёр


нуурыг бий болгосон нь гадаадын жуулчдын сонирхлыг гойд татдаг билээ. Ууланд аялах дуртай аялагчдын сонирхлыг татдаг бүс нутгийннэгнь их Богд уул юм.

### “БАЯНХОНГОР – ӨВӨРХАНГАЙ – ӨМНӨГОВЬ – АРХАНГАЙ” -Г ХОЛБОХ АЯЛАЛЫН МАРШРУТ



- Архангай аймгийн Хозогын тогоо, Тайхар чулуу Тэрхийн цагаан нуур зэрэг жуулчдын сонирхлыг татдаг аялал жуулчлалын бүс нутгаар аялаад Эгийн даваагаар даваад Баянхонгорын хангайн бүсийн аялалын маршруттай холбогдох боломжийг бүрдүүлэх
- Монголын эртний нийслэл Хар хорин хотын туурь, Эрдэнэзуу, Орхоны хүрхрээ, Төвхөний хийд, Найман нуурын үзэсгэлэнт байгалийн үзэж сонирхсон жуулчдыг Баянхонгорын Шаргалжуутын маршрутад холбох
- Гадаадын жуулчид Монголын говь нутгийг үзэх гэж зорьж очдог Өмнөговийн аялалын маршрутыг Баянхонгорын говьруу холбож "Өмнөговь-Баянхонгор" гэсэн аялал жуулчлалын онц сонирхолтой маршрутыг бий болгох шаардлагатай

### ХАНГАЙ БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТ



Баянхонгор аймаг нь Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлогоор Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Орхон аймаг зэрэг гадаадын жуулчдын сонирхлыг гойд татдаг бүс нутагт багтдаг нь аялал жуулчлалын “**Бүс нутгийн маршрут**”-ыг бий болгож аялал жуулчлалаас их хэмжээний орлого олох боломжийг бүрдүүлж байгаа болно.

Аялал жуулчлалын салбарын онцлог гэвэл бие биенийгээ дэмжин ажиллах кластерын зохион байгуулалтаар хөгжихөд хамгийн тохиромжтой бөгөөд өөрөөр хэлбэл энд газар зүйн хувьд ойролцоо байршдаг үзэсгэлэнт газар, үйлчилгээний багц, компаниудын сүлжээ, зочид буудал, хоол, худалдаа, амралтын газар болон соёлыг үйлчилгээ бүгд орж байгаа.

Мөн сүүлийн үед хөлсний тээвэр, түрээсийн унаа(машин, мотоцикль, дугуй) зэрэгдөж болсон бөгөөд жуулчдыг олон газраар зэрэг орсх боломжийг улам нэмэгдүүлж байна гэсэн үг.



Эдгээр кластерыг бүрдүүлэхэд хувийн хэвшлийн компаниуд идэвхтэй оролцох боловч зохион байгуулалт, нэгдсэн удирдлага, зохицуулалт болон мэдээллийн түгээлтийг сайжруулахад нь зайлшгүй төрийн оролцоо чухал юм.

Аймгийн үзэсгэлэнт газрууд, маршрутын нэгдсэн танилцуулга англи хэл дээр байхгүй байна. Монгол хэл дээр вэбсайт, сошиал медиаг ашигласан зарим хуудас байгаа ч хугацааны хувьд байнга шинэчлэл хийгдэдгүй, шинэ мэдээ мэдээлэл ховор байдгийг анхаарч нэгдсэн байдлаар хийж портал болгох шаардлагатай.

Аймгийн аялал жуулчлалын өөр нэг том нөөц бол нутгийн иргэд. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал(НИТАЖ)-ыг хөгжүүлэх нь нүүдлийн ахуй соёлоо хадгалан үлдэх, ерхийн орлогыг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай эвент хөгжүүлснээр жуулчдын урсгалыг татах боломжтой.

Баянхонгор аймгийн аялал жуулчлалыг голлон хөгжүүлэх сумдад нутгийн иргэдийг бэлтгэж эхлэх нь аялал жуулчлалын зах зээлийн том боломж. Нутгийн иргэд тур оператор компаниудтай хоршин ажилласнаар орлогын шинэ эх үүсвэрийг бий болгож орлогоо нэмэгдүүлэх болно.

Аялал жуулчлалын нэг үндсэн хэсэг болох дотоодын аялаг жуулчлалыг хөгжүүлэх том боломж, ихээхэн нөөцийг бид алдсаар байна. Баянхонгор аймаг нь дотоодын аялал жуулчлалын нэг хэлбэр болох эрүүл мэндийн аялал жуулчлалыг олон жил хөгжүүлсэн баялаг туршлагатай гэж болно. Гэхдээ бид үүнийгээ аялал жуулчлалын нэг хэлбэр гэж тооцож үзээгүй ирсэн нь харамсалтай.

Монголд ганцхан Баянхонгор аймагт л байдаг байгалийн өвөрмөц тогтоцтой, нэмэх 96 градуст буцалж байдаг, ардын эмчилгээний гол төв болсон Шаргалжуутын рашаан сувилалд жилд 7000 амрагч гадаад, дотоодоос ирж сувилуулж байдаг. Мөн Өхөг, Ичээт, Халиут, Өргөөтийн рашаанууд Холбоолж, Үүдийн давст нуурууд зэрэг ардын уламжлалт эмчилгээний төвүүдэд жилд олон зуун хүн ирж үйлчлүүлдэг.

Иймээс эдгээрийг аялал жуулчлалын нүдээр харж, аялал жуулчлалын статистиكت бүртгэлжүүлж, аялалын маршрут, үйлчилгээний цогцолборуудыг бэйгуулж, аялал жуулчлалын томоохон төв болгосноор Баянхонгор аймаг дэлхий даяар утаагүй үйлдвэрлэл, нүдэнд үл үзэгдэх экспорт гэж нэрлэгддэг аялал жуулчлалын салбараас ихээхэн орлого олж аймгийнхаа эдийн засгийг солонгоруулах бололцоотой.

Судлаачид 1 жуулчин ирхэд жолооч, эрчуулагч, үйлчлэгч, тогооч, худалдаачид гэх мэт 20 шахам ажлын байр идэвхждэг гэж тооцож гаргасан байдаг. Энэ жишигээр үзвэл Баянхонгор аймаг аялал жуулчлалыг хөгжүүлснээр ажлын байрыг их хэмжээгээр нэмэгдүүлж, ажилгүйдлийг устгаж, иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх боломжтой нь харагдаж байна.

Цаашид Хангай бүс нь хойд талаараа ОХУ, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг учир БНХАУ-аар аялсан жуулчид Баянхонгорын говь, хангайн үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газруудаар аялаад ОХУ-руу гарах, ОХУ-аас Монголоор дамжаад БНХАУ-руу гарах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

### **2.4.3. БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР:**

Барилгын салбар Баянхонгор аймагт хөгжиж ирсэн 60 шахам жилийн баялаг түүхтэй. МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1958 оны 3-р сарын 10-ны өдрийн 45/50-р тогтоолоор Барилгын тасгийг ХАА-н барилгын анги болгон өргөтгөж бие даасан барилгын байгууллагыг үүсгэн байгуулснаар тус анги 1958-1960 онд жилд 1,2-2,0 сая төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, Байдрагын САА, Баян-Овсо сумын МААМС-ын төвийг барьж байсан түүхтэй.

БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 23-р тогтоолоор Баянхонгор аймгийн барилга угсралтын контор, авто машин хүнд механизмын бааз зэрэг барилгын материалын олон салбаруудыг нэгтгэсэн аймаг дундын "Техник туслалцааны барилга трест"-ийг шинээр байгуулснаар 44,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 1200 гаруй ажиллагсадтай, жилдээ 39,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр аж ахуйн томоохон салбар болж өргөжсөн байдаг.

Баянхонгор аймаг нь гөлтгөнө, базалт, асбест, шохойн чулуу, тоосгоны шавар, өнгөлгөөний чулуу, гялтагнуур, гантиг, хүрмэн чулуу, эрдэс будаг, сайн чанарын элс, хайрга зэрэг барилгын материалын нөөц ихтэй аймгуудын тоонд ордог.

Монгол улсын Засгийн газрын боловсруулсан Монгол орныг аж үйлдвэржүүлэх зураглалд Баянхонгор аймгийн барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр тусгагдсан байгаа нь тус аймагт барилгын материалын үйлдвэрлэлийн салбар хөгжих ихээхэн боломж, ирээдүй байгааг харуулж байна.


Өнөөгийн байдлаар Баянхонгор аймагт тоосгоны 2 үйлдвэр, сум бүрд блокны үйлдвэр, аймгийн төвд бетон зуурмагийн 3 үйлдвэр, элс хайрганы 2 үйлдвэр, полистрол хавтан, АСА хавтан, пено блокны үйлдвэр, вакум цонх, хаалганы үйлдвэр, замын бродуур, явган хүний замын хавтангийн үйлдвэр зэрэг барилгын материалын олон үйлдвэр ажиллаж байгаа хэдий ч аймагт байгаа барилгын материалын түүхий эдийн нөөцийн багахан хувийг л ашиглаж байна.

Тэрчлэн аймгийн хэмжээнд басигдаж буй орон сууцанд жилд дунджаар 6243 тонн цемент, 3521 тонн арматур, 2 164 461 ширхэг тоосго, 151 231 ширхэг блок, 1207 м<sup>2</sup> вакум цонх шаардагдаж байгааг орон нутгийн үйлдвэрүүд хангаж чадахгүй байгаа нь цаашид энэ чиглэлийн үйлдвэрүүдийг хөгжүүлэх боллоцоотой нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд аймгийн бүтээн байгуулалт ихээхэн өргөжиж 2015 оны байдлаар нийт улсын болон орон нутгийн төсвийн 4334,9 төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 3388,4 сая төгрөг буюу 78,0 хувийг барилга угсралт, 165,0 сая төгрөг буюу 3,8 хувийг их засвар, 781,5 сая төгрөг буюу 18,0 хувийг авто зам засвар, арчлалтын ажил тус тус эзэлж байна.

2012 оны жилийн эцсийн дүнгээр аймгийн төвд 1050 айлын нийтийн орон сууц байсан бол сүүлийн 3 жилийн хугацаанд 1136 айлын орон сууц ашиглалтад орж 70 жилийн хугацаанд баригдсан орон сууцны тооноос давсан үзүүлэлт болжээ.

*Баянхонгор хотод баригдсан орон сууцны барилгууд*



1974 оноос хойш засвар шинэчлэл хийгдээгүй Төв талбай, ахмадын цэцэрлэгт хүрээлэнд 2014 онд орон нутгийн хөгжлийн сангийн 898 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн тохижуулж, 1970 онсос хойш засвар, шинэчлэлийн ажил хийгээгүй байсан аймгийн “Төв цэнгэлдэх хүрээлэн”-нд 370 сая төгрөгөөр ергөтгөл, засварын ажлыг хийж 2500 хүний суудал шинээр байрлуулан нийт 3508 хүний



суудалтай бслгож дотор хэсэгт олон улсын стандартын шаардлага хангасан гар бөмбөг, хөл бөмбөг, сагсан бөмбөгийн талбай, гүйлтийн зам зэргийг шинээр хийжээ.

Аймгийн “Төв цэцэрлэгт хүрээлэн”-гийн тохижилтийн ажлын хүрээнд нийт 6.3 га талбайд хиймэл нуур, явган зам талбай, ногоон байгууламж, авто зогсоол зэрэг




ажлууд хийгдэхээр тусгагдаж одоогийн байдлаар газар шорооны ажил бүрэн дуусч зам талбайн ажил хийгдэж байна.

Гандангийн урд 0,8 га талбайд ногоон байгууламж, сүүдрэвч, авто зогсоол, тэглоомын талбай зэрэг тохижилтийн ажлыг, “Эрдэнэ мандал хайрхан”-ы тохижилтын ажлын хүрээнд авто зогсоол, гэрэл-үүлэг,



амралтын тавцан, 624 шат зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.



2012 онд аймгийн хэмжээнд 31,4 км инженерийн шугам сүлжээ байсан бол 2015 онд 63,2 км болж инженерийн шугам сүлжээ 2 дахин нэмэгдсэн. Мөн 1000 м<sup>3</sup> багтаамжтай 2 ш усан сан /резервуар/ цэвэрлэх байгууламжийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

1941-2012 оны хооронд 71 жилийн хугацаанд аймгийн төвд 14,7 км хатуу хучилттай авто зам баригдаад байсан бол сүүлийн 3 жилийн хугацаанд дээрхи 14,7 км авто замын 5,6 км-т нь өргөтгөл шинэчлэлт хийжээ. Энэ ажлын хүрээнд зам дагуух ногоон байгууламж, услалтын систем, үерийн ус зайлуулах систем, гэрлэн дохио, явган хүний зам зэрэг ажлууд хийгдэж, гэр хороолол дундуур 10 км авто замыг шинээр барих ажил 75 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Ингэснээр Баянхонгор хотын хэмжээнд нийт 24,7 км хатуу хучилттай авто замтай болжээ.

Баянхонгор сумд дулааны станц, 2,7 дугаар багт инженерийн шугам сүлжээ, үерийн хамгаалалтын далан, 4,5-р багт инженерийн шугам барих зэрэг зураг төсөв хийгдсэн төслүүдийг эхлүүлэхээс гадна хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 7 багт нийтийн орон сууцны хороолол, 4,5-р багт амины орон сууцны хороолол барихаар төлөвлөж байна.

#### **2.4.4. УУЛ УУРХАЙН САЛБАР:**

Баянхонгораймгийн нутаг дэвсгэрт геологийн холбогдолтой судалгаа 1922-1925 онд Америкийн байгалийн түүхийн музейн Тэв Азийг судлах экспедицийн геологичид (Х.Берки,Ф.Моррис) Хангайн нурууны өмнөт хэсэг, нууруудын хөндийн мезо-кайнозойн хурдсуудыг нарийвчлан судалсан ажлаас эхлэлтэй юм.

АА.Макавеев, М.Певцов, ТН.Потанин зэрэг судлаачид 1932-1939 онд палеозой, цэрд-палеогений (Говийн хурдас) хурдас мезозойн гүний чулуулгийн судалгаа болон Ар, Өвөр Чулуут, Мухар Эрэг зэрэг алтны шорсон хуримтлалыг гар аргаар ашиглаж байсан тэр үеэс тухайн бүс нутагт геологийн холбогдолтой судалгааг хийж байжээ.

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт одоогоор ашигт малтмалын 35 төрлийн 79 орд, 176 гаруй илрэг тогтоогджээ.

Тухайлбал, алтны 53 ордны зэрэгцээ алт-мөнгөний 1, алт-кадми 1, алт-зэсийн 2, молибден зэсийн 2, зэсийн 1, хүрмэний 1, тоосгоны шаврын 3, элс-хайрганы хольц 1, барилгын элсний, эрдсийн будагны 2, асбестний 1, давсны 4, барилгын чулууны 4, шохойн чулууны 2 орд, нийтдээ 79 орд тогтоогдсон байна.

Мөн нүүрсний 27 илрэл, шатдаг занарын 3 илрэл, алтны 50, мөнгөний 4, төмрийн 19, хоромын 1, марганецийн 1, зэсийн 20, хар тугалганы 1, цайрын 1, никелийн 1, гянт болдын 1, эрдсийн будагны 1, гөлтгөний 1, өнгөлгөөний чулууны 5, молибдений 2, хайлуур жоншны 3, хайлшийн кварцын 11, асбестний 2, бал чулууны 2, исландын жоншны 1, гялтгануурын 2, өнгөт чулууны 13, давсны 2, фосфоритны 1, шохойн чулууны 2 илрэл нийтдээ 176 илрэл тогтоогджээ.

Аймгийн хэмжээнд 2015 оны байдлаас нийт 18 сумын нутаг дэвсгэрт 166 иргэн аж ахуйн нэгж 627158,39га талбайд тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас ашиглалтын зөвшөөрөлтэй 72 иргэн, аж ахуйн нэгж 53 808,82га талбайд, хайгуулын зөвшөөрөлтэй 94 иргэн, аж ахуйн нэгж 573351,57га талбайд тус тус тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хөрөнгө сруулалтаар нь ангилж үзвэл дотоодынхөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 123, гадаадын хөрөнгө оруулалтхамтарсанажахуйннэгж18, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай 25 аж ахуйн нэгж байна.

Баянхонгор аймаг нь алтны шороон ордны нөөц ихтэй, олборлоход хялбар, зардал бага, борлуулахад түвэг чирэгдэл багатай зэрэг давуу талтай алтны шороон ордыг компани, нөхөрлөл, нинжа хэлбэрээр олон жилийн турш олборлссон нь байгаль орчинд сөрөг нөлөө ихээр үзүүлж, олсон газар нөхөн сэргээгдэлгүй эвдэрч үлдсэн.

Алт олборлолтын зохисгүй байдлыг дахин давтагдуулахгүй тулд аймаг сум, орон нутгийн захиргаанаас уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинг сайн судалж, нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан, иргэдийн амьдралд дэмжлэг болсон, байгаль орчинд хал багатай уул уурхайг хөгжүүлэх, төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа тооцоонд суурилж хийх нь чухал юм.

Эдийн засгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтөнд дараах ордуудад геологийн нарийвчлсан хайгуулгаар нөөцийг шинэчлэн тогтоох шаардлагатай.

- Цементийн гол түүхий эд болох Баянлиг сумын нутагт орших гөлтгөний илрэлийг цаашид нарийвчлан судгаж орд болгон ашиглах
- Баян-Өндөр, Шинэжинст сумын нутгийг дамнан орших алт, зэс, молбедины Цэнхэр номин, Хөндий зэрэг томоохон ордуудын нөөцийг тогтоох

Аймгийн эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулахуйц хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай.

- Дөвөнтийн уурхайн хүрэн нүүрсний ордыг түшиглэн утаагүй түлшний үйлдвэр байгуулах, орд ашиглалтын технологийг боловсронгуй болгох
- Улсын бслон бүс нутгийн хатуу хучилттай авто зам хүртэл хийх уурхайн тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх талаар төрийн захиргааны байгууллага, хөрөнгө сруулагчидтай жил бүр хамтарсан семинар бусад хэлбэрийн ажлыг зохисн байгуулах

- Тэр, уул уурхай, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 4 тапын түншлэлийг хөгжүүлэх
- Нутгийн иргэдэд хуулийн дагуу ашиглалт, хайгуул хийж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх тал дээр сум орон нутгийн удирлагууд анхаарч ажиллах
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг дэмжиж ажиллах

ГУРАВ: "БАЯНХОНГОР АЙМГИЙГ 2016-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ХЭТИЙН ЗОРИЛТ" - ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЗОРИЛТУУД



## **“НЭГ: ХҮНИЙ ХӨГЖИЛ-ХОНГОРЫН ХӨГЖИЛ”**

### **ҮНДСЭН ЗОРИЛТ - 1.**

*Хүнээ хөгжүүлж эрүүл чийрэг, идэвх санаачилгатай, чадварлаг, хөдөлмөрч, бүтээгч иргэдийг төлөвшүүлснээр өөрийгөө тэтгэх чадвартай өрхийг нэмэгдүүлж, нийгэмд эзлэх хувь хэмжээ, хамрах хүрээг өргөжүүлэх “ХӨГЖСӨН ИРГЭН-БИЕ ДААХ ЧАДВАРТАЙ ӨРХ” бодлого*



### 3.1.1. Хүний хөгжил

#### Зорилт 1.

“Амьдрах Ухааны Сургууль”(АУС) насан туршийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт иргэдээ амьдрах ухаан болон аж ахуй эрхлэх арга ухаан, эрүүл аж төрөх дадал хэвшилд сургаж, сонирхсон чиглэлүүдээр нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгон ирээдүйдээ итгэх итгэл, баялаг бүтээх сэтгэхүйтэй болгож, ахуйн хэрэглээний гадаад хэлний зохих мэдлэг, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг амьдрал ахуйдаа ашиглаж сурах боломжийг бүрдүүлэх

#### Зорилт 2.

Иргэн бүрийн аймгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах бололцоо нөхцөлийг бүрдүүлж, тэдний гаргасан нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах бололцоотой “Шилдэг бүтээл, дэвшилтэт технологи, оновчтой санал”-ыг үнэлж, төрөөс худалдан авч урамшуулах тогтолцоог бий болгон “Шилдэг бүтээл, оновчтой санал” (ШБОС)-ын уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, шалгарсан бүтээлийг бодлогоор дэмжиж үндэсний болон гадаадын зах зээлд гарах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь туслах

#### Зорилт 3.

Ахмадууд, хүүхдүүд, эмэгтэйчүүд, өрхийн тэргүүлэгчид гэхмэтнийгмийнбүлгүүд болон барилгачид, эдийнзасагчид, инженерүүд, багшнар, урчууд, дархчууд, мужаанууд гэх мэт мэргэжлийн чиглэлүүдээр зохион байгуулалтад оруулж дэмжиж, хөгжүүлэх замаар аймаг, орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд идэвхи, санаачилгатай оролцуулах бололцоог бүрдүүлэх.

#### Зорилт 4.

Бүх нийтийн “Монгол бичиг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Хос бичигтэн” аймаг болох зорилтыг хэрэгжүүлэх

#### Зорилт 5.

Ажил мэргэжлийн уралдаануудыг бизнесийн төрөл чиглэл бүр дээр зохион байгуулж шилдгүүдийг алдаршуулах, шилдэг ажилчдыг гадаад, дотосдод мэргэжил ур чадвараа дээшлүүлэх, туршлага судлахад нь дэмжлэг үзүүлэх, гадны зөвлөх мэргэжилтнүүдийг урьж дагалдуулах замаар хөгжүүлэх

#### Зорилт 6.

Шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд, их дээд сургуулиудтай хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, “үндэсний технологи, инноваци, судалгаа шинжилгээ, бизнес инкубаторын төв”, МСҮТ болон Политехник коллежийг түшиглэн “Үйлдвэрлэлийн сургалт дадлагын төв”-ийг тус тус байгуулан, бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг бий болгох

#### Зорилт 7.

Ажил олгогчид, үйлдвэрлэгчид мэргэжилтэй ажиллах хүчнийг МСҮТ, Коллежид бэлтгэхдээ, ажиллах хүчиндээ тавигдах тусгай шалгуурыг тавьж, гурвалсан гэрээ(ажил олгогч, суралцагч, МСҮТ болон коллеж)-г байгуулж, Мэргэжлийн сургалт явуулдаг сургалтын байгууллагуудад суралцагсдыг орчин үеийн техник, тоног төхөөрөмж дээр дадлага хийлгэх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор дадлагын бааз болох

бололцоотой ААН-үүдийг сонгож хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, тоног төхөөрөмжөөр хангахад нь дэмжлэг үзүүлэх

#### **Зорилт 8.**

Аймгийн шилдэг мэргэжилтнүүдийг сонгон шавь сургалт зохион байгуулах нөхцөл бололцоог бүрдүүлж, шавь сургалтыг зохион байгуулж тодорхой үз дүнд хурч байгааиргэдийг урамшуулдаг тогтолцоог бий болгох

#### **3.1.2. Боловсрол**

#### **Зорилт 9.**

Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж хүн амын боловсролын түвшинг ахиулан орон нутгийн онцлогт тулгуурлан хүүхдийг амьдрал, хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, ЕБС-ийн ахлах сургуулийн хэв шинжийг оновчтой тогтоох.

#### **Зорилт 10.**

Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж тэдний мэргэжлийн болон багшлахуйн ур чадварыг дээшлүүлэх, боловсролын салбарт ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн “Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

#### **Зорилт 11.**

Иргэд, аж ахуй нэгж, байгууллага хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулахыг бодлогоор дэмжих.

#### **Зорилт 12.**

Хүүхдийг цэцэрлэгээс эхлэн авьяас чадвараа нээхэд нь туслах зорилгоор хүүхдийн ухаан сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн “**үндэсний онцлоготой тогтоомийн үйлдвэр**” байгуулж аймгийн бүх цэцэрлэгийг хангах, сургуулийн өмнөх насны хүүхдүүд болон ЕБС-ийн сурагчдын сургалтын хөтөлбөрт Монголын оюун ухааны академийн сургалтын программыг оруулж хүүхдээ хөгжүүлэх бодлогыг системтэй хэрэгжүүлэх

#### **Зорилт 13.**

Сургуулийн хүүхдүүдэд хөдөлмөрийн хүмүүжил төлөвшүүлэх зорилгосор сум бүр “**хөдөлмөр, амралтын зуслан**” ажиглуулж, сүү сааль боловсруулах, мал төллүүлэх, ноослох, хаврын тариалалт, намрын ургац хураалт, хандлан тэжээл бэлтгэх ажилд оролцуулах

#### **Зорилт 14.**

Хүүхдийн техник сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр “**Запуу зохион бүтээгч клуб**” -ыг сум бүрт ажиллуулж “Робокон-Баянхонгор” тэмцээнийг жил бүр зохион байгуулах

#### **Зорилт 15.**

Дэлхий нийтийн хэрэглээ болсон компьютер, англи хэл, монгол улсын хоёр хөрш орны хэл болох Орос, Хятад хэлний анхан шатны сургалтыг дунд сургуулиас нь эхэлж, ахлах сургуульд гүнзгийрүүлэн суралцах сургалтын бодлогыг хэрэгжүүлэх

#### **Зорилт 16.**

Сургууль, эцэг эх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн, хөрөнгө оруулалт хийсэн иргэд, аж ахуй нэгж, байгууллагыг бодлогоор дэмжиж ажиллах.

#### **Зорилт 17.**

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг үйлдвэрлэлийн салбаруудтай танилцуулж, сонирхсон мэргэжлийн чиглэлүүдээр нь мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулж ахлах сургуулиудыг сургалтын тоног төхөөрөмж, дадлага лабортарийн анги танхимтай болгох.

### **3.1.3. Соёл**

#### **Зорилт 18.**

Түүх соёлын дурсгал болон байгалийн үзэсгэгэнт газруудыг түшиглэсэн аялал жуулчлалыг соёлын цогц үйлчилгээтэй хослуулан хөгжүүлж, соёл урлагийн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах.

#### **Зорилт 19.**

Соёлын өвийг хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах, баяжуулан хөгжүүлж буй биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх.

#### **Зорилт 20.**

Соёлын салбарын байгууламж, техник технологийн шинэчлэл, инновацийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлж, орчин үеийн технологи бүхий кино театр, соёлын төвийг аймгийн төвд шинээр байгуулах.

#### **Зорилт 21.**

Түүх соёлын үнэт өвүүд, алдартай хүмүүсийн бүтээлийн үзэсгэлэнг жил бүр аймгийнхаа нийт сум багуудад явуулын байдлаар сурталчилж, **“Соёл, урлагийн их наадам”**-ыг 2 жилд нэг удаа аймгийн хэмжээнд зохион байгуулах.

#### **Зорилт 22.**

Үндэсний болон дэлхийн сонгодог уран бүтээлүүдийг судлан найруулж, иргэддээ орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангасан соёлын бүтээгдэхүүнээр үйлчлэх, үндэсний болон дэлхийн сонгодог урлаг, тайз дэлгэцийн болон соёлын бүтээл, туурвилыг бүтээж улс, тив, дэлхийн чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан уран бүтээлч, ардын авъяастан, багш, найруулагчдыг дэмжиж алдаршуулах тогтолцоог бүрдүүлэх

#### **Зорилт 23.**

Соёлыг үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ **“төр-соёл урлаг-бизнесийн нэгдэл”**-ийг хангасан кластерийн зохион байгуулалтаар хөгжүүлэх.



## “ХОЁР: ЭРҮҮЛ ХҮН-БАЯЛАГ БҮТЭЭНЭ”

### 3.2. ЭРҮҮЛ ХҮН-БАЯЛАГ БҮТЭЭНЭ

#### **Зорилт 24.**

“Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

#### **Зорилт 25.**

Аймгийн төвд уламжлалт эмчилгээ, үйлчилгээний төв байгуулж, Их, Бага Шаргагжуут, Өхөг, Өргөөт, Халиут зэрэг халуун, хүйтэн рашаан, Холбоолж нуур болон Үүдийн нуурын давс, шаврын эмчилгээний орд газар, говийн элсийг түшиглэн ингэний ундаа, үүний айраг, саам, эмийн ургамлыг ашиглан уламжлалт эмчилгээний сувилал байгуулах санал санаачилгыг дэмжих

#### **Зорилт 26.**

Аймгийн нэгдсэн эмнэлгийг нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонь орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадвартай нарийн мэргэжлийн, өндөр ур чадвартай эмч мэргэжилтэнг систем дэс дараатай бэлтгэх, орон нутагтаа нарийн мэргэжлийн, тусламж үйлчилгээг үзүүлэх боломж нэхцөлийг бүрдүүлэх

### **Зорилт 27.**

Эрүүл аж төрөх дадал хэвшлийг иргэдэд төлөвшүүлэх ажлыг үе шаттай бүх нийтийн хүртээл болгох зорилгоор “эрүүл өрх”, “эрүүл байгууллага”, “эрүүл баг”, “эрүүл сум” болзолт уралдааныг аймгийн хэмжээнд өрнүүлж шилдэг хамт олныг жил бүр шалгаруулж шагнаж урамшуулдаг тогтолцоог бий болгох

### **Зорилт 28.**

Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн сэтгэл ханамжтай ажиллах амьдрах нийгмийн баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэн ёс зүй хариуцлагын тогтолцоог өндөрсгөж, мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн сургаж ажиллуулах замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Эмнэлгийн мэргэжилтний хөгжил” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

### **Зорилт 29.**

Малчид болон алслагдсан бүс нутагт ажиллаж, амьдарч буй иргэдэд үйлчлэх иж бүрэн тоноглогдсон нүүдлийн амбулатори, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх нисдэг тэрэгтэй болох

### **Зорилт 30.**

Өвчлөлт, нас баралтад нөлөөлж буй дотоод хүчин зүйл болох амьдралын буруу хэвшил, дадал, гадаад хүчин зүйл болох усны хатуулаг, агаар болон хөрсний бохирдол, осол гэмтлийг бууруулах чиглэлээр систем, дэс дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх

### **Зорилт 31.**

Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, тусламж үйлчилгээний төвлөрлийг саарууланүйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

### **Зорилт 32.**

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх санал санаачилгыг идэвхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн их спортыг дэмжиж “Баянхонгор бага олимп” спортын наадмыг 4 жилд тутамд зохион байгуулах.

### **Зорилт 33.**

Тив, дэлхий, улс, аймаг бүсийн хэмжээний спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан тамирчид, багш, дасгалжуулагчдыг алдаршуулж, урамшуулах тогтолцоог бүрдүүлэх.

### **Зорилт 34.**

Сум бүр иргэдийг явган болон уулын аялал, дугуй, мотоцикль, авто машин, үхэр, морь, тэмээн аялал, гүйлт, цана, тэшүүрээр хичээллэхэд чиглэгдсэн аялалын маршрут, аялал зохион байгуулах хөтөчүүдийг бэлтгэж, чөлөөт цагаараа бие бялдараа хөгжүүлж, алжаал ядаргаагаа тайлж, зөв зохистой амрах нөхцлийг бүрдүүлэх



**“ГУРАВ: ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЖ ҮЙЛДВЭР,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХОСЛУУЛСАН КЛАСТЕР-  
ХОНГОР НУТГИЙН ИРЭЭДҮЙ”**

### **3.3.ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЖ ҮЙЛДВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХОСЛУУЛСАН КЛАСТЕР-ХОНГОР НУТГИЙН ИРЭЭДҮЙ**

#### **3.3.1. ХАА-н үйлдвэрлэл**

##### **Зорилт 35.**

Сүү, мах, ноос ноолуурын үйлдвэрлэлийн голлох бүс нутгуудын мал сүргийг үйлдвэрлэлийн чиглэлээр нь бүсчилэн хөгжүүлж МАА-н түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх

##### **Зорилт 36.**

МАА-н мэргэжилтнүүдийг чадавхжуулах, давтан сургах, сум багийг орчин үеийн дэвшилтэд багаж, тонсг төхөөрөмжөөр дэс дараатай хангаж, нийт мал сүргийг угаалга, тарилга туулгалтад бүрэн хамруулан өвөлжөө, хаваржааг ариутган халдваргүйжүүлэх, сүү, махны чиглэлийн мал сүргийг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгийн хил хязгаарыг тодорхойлж энэ бүс нутагт мал эмнэлэг-эрүүл ахуйн онцгой дэглэм тогтоож **“эрүүл мал-эрүүл хүнс”** бодлогыг хэрэгжүүлэх

##### **Зорилт 37:**

МАА хөгжсөн улс орнуудад мал сүргийг өсгөж үржүүлж байгаа 3 хэлбэрийг Баянхонгор аймагт хослуулан хөгжүүлэх стратегийг баримтлана. Үүнд:

- Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт мах, сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн, **“эрчимжсэн мал аж ахуй”** -г хөгжүүлэх
- Аймгийн төвөөс 50-150 км-ийн алслагдсан тойрогт өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн малыг нутгийн малтай эрлийжүүлж сайжруулсан, **“хагас суурин мал аж ахуй”**-г хөгжүүлэх
- Аймгийн төвөөс 150 км-ээс цааш алслагдсан тойрогт нутаг орондоо дасан зохицсон, ашиг шим сайтай нутгийн шилмэл омог, үүлдрийн мал сүргийг **“уламжлалт бэлчээрийн арга”** -аар өсгөж үржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

##### **Зорилт 38.**

Тус аймагт бэлтгэж буй махны 25-30 хувийг үхрийн, 35-40 хувийг хонины, 10-15 хувийг ямааны, 15-20 орчим хувийг адууны мах эзэлдэг ба гахай, тахианы махны үйлдвэрлэл сул хэгжиж буйд дүгнэлт хийж, махны чиглэлийн үхэр, хонь, адууны тоо толгойг өсгөж, гахай, тахианы аж ахуйг бий болгож, махны нөөцийг нэмэгдүүлж, экспортлох

##### **Зорилт 39.**

Инженерийн хийцтэй услалтын системийн ашиглалтийг сайжруулж, МАА-гаа дэмжсэн газар тариаланг хөгжүүлэх хөгжлийн бодлогыг иш үндэс болгон Байдраг, Түйн голын ай савын дагуух инженерийн хийцтэй услалтын системүүдийн нийт талбайн 40 хүртэл хувьд төмс, хүнсний ногоо, 60 хүртэл хувьд нь малын тэжээлийн ургамал, говийн бүсийн услалтын системүүдийн нийт талбайн 30 хувьд төмс, хүнсний ногоо, 70 хувьд нь тэжээлийн болон эмийн ашигт ургамал тус тус тариалах бодлогыг үе шаттай хэрэгжүүлж, дотоодын хэрэгцээгээ 100 хувь хангах

##### **Зорилт 40.**

Бүс нутгийн хөрс, уур амьсгалын онцлогт тохирсон тэмс, хүнсний нэгоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамалын нэр төрлийг олшруулж, нутагшсан сортын үрийг бий болгох, хөрс боловсруулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, орон нутгийн эрдэс болон шим бордооны үйлдвэрлэл, хэрэглээг өргөжүүлэх, тариалангийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах замаар газрыг зах зээлийн эргэлтэнд оруулж ашиглалтыг сайжруулах ажлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх

#### **Зорилт 41.**

Баянхонгор хот, Шаргалжуутын халуун рашааныг түшиглэн 4 улирлын ажиллагаатай хамгаалагдсан хөрсний тариалалтыг орчин үеийн техник, технологид тулгуурлан зохион байгуулан, хагас болон бүтэн боловсруулсан хүнсний ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох

#### **Зорилт 42.**

ХАА-н үйлдвэрлэлийн салбарт ажиллагсадын хамтарч, хоршиж ажиллах зохион байгуулалтын шинэ тогтолцоог бий болгох замаар мал аж ахуйн ба газар тариалангийн үйлдвэрлэгч дэд чанартай үйлдвэрлэлийн орц олж авах, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь зах зээлд борлуулахад зуучлах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд учирдаг санхүүгийн болон байгалийн эрсдлийг бууруулах стратегийг хэрэгжүүлэх

### **3.3.2. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл**

#### **Зорилт 43:**

Сүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бүс нутгийн мал сүргийг өндөр ашиг шимтэй малаар сайжруулах, сүү үйлдвэрлэлийн бүс нутгуудад бэлтгэсэн сүүг уламжлалт технологи болон орчин үеийн технологи ашиглан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж олон нэр төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав баглаа боодолжуулах, дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг кластерийн зохион байгуулалтаар хөгжүүлэх

#### **Зорилт 44.**

Дулааны улиралд сүүний нөөцийн илүүдэл үүсч, хүйтний улиралд сүүний хангамжинд хомсдлыг бий болгодог өнөөгийн тогтолцоог тэнцвэржүүлэх үүднээс **“хуурай сүүний үйлдвэр”** байгуулах

#### **Зорилт 45:**

Махны чиглэлийн мал үржүүлэхээр тодорхойлсон бүс нутгуудад эхний ээлжинд мал бордох цэгүүдийг байгуулж, махны гарцыг нэмэгдүүлэх, Баянхонгор хотод байгуулагдсан мах боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг сайжруулж, **“бүсийн төвийн сумдад махны жижиг сворын үйлдвэр”** -үүд байгуулан шинэ технологи нэвтрүүлснээр олон улсын стандарт, зах зээлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

#### **Зорилт 46.**

Ноос, ноолуурын чиглэлийн өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, ноос, ноолуур болон арьс ширийг уламжлалт технологи болон орчин үеийн технологи ашиглан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж олон нэр төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав баглаа боодолжуулах, дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх. Үүнд:

- Сум бүрт түүхий эдийн анхан шатны тордолт хийх цэг Баянхонгор суманд **“арьс шир боловсруулах үйлдвэр”** байгуулах



- Байдраг үүлдрийн хонины угшлыг цуглуулан цөм сүрэг бий болгон үржүүлж, хивсний сайн чанарын ноос бэлтгэн үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлэх, хивсний утас ээрэх үйлдвэрийг байгуулж үндэсний онцлогтой **"гар хивсний үйлдвэр"** байгуулах
- Сарлагын хөөвөр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх үйлдвэрүүд байгуулах
- Ноолууранд анхан шатны боловсруулалт хийх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр барих санал, санаачилгыг бодлогоор дэмжих

#### **Зорилт 47.**

Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээмжийг нэмэгдүүлэх, гар ажиллагааг механикжуулах, өрхийн үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх зорилгоор бага оворын дэвшилтэд тоног төхөөрөмжийн мэдээллийн сан бүрдүүлж, иргэдэд сурталчлах, бага оворын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээс, лизенгийн үйлчилгээг хөгжүүлэх

#### **Зорилт 48.**

Мэргэжлийн байгууллагуудтай хамтран аймгийнхаа иргэдийн хэрэгцээнд зориулж импортолж байгаа бараа бүтээгдэхүүн импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүнээс аймаг орон нутагт үйлдвэрлэх бололцоотой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгааг гаргаж, импортыг орлох хэмжээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхээр төсөл, хөтөлбөр боловсруулсан, энэ чиглэлийн бизнесийг хийж эхэлж байгаа иргэд, өрх, жижиг бизнес эрхлэгчдийг сонгон Баянхонгор хотод баригдаж байгаа "Ажилсаг төв"-ийн базилгыг түшиглэн байгуулах **"Баянхонгор үйлдвэр технологийн парк"**-ийн **"Бизнес инкубаторын төв"** -д бойжуулах

#### **Зорилт 49.**

Улаанбаатараас баруун аймаг явдаг хэвтээ тэнхэлгийн хатуу хучилттай авто зам Баянхонгор аймгийн нутгаар дайран өнгөрдөг 300 шахам км замын дагуу тодорхой, оновчтой байршлуудыг сонгон олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний төвүүд байгуулж, төвүүдийн ойролцоо байгаа хөдөөгийн иргэдэд зах зээлийн бслөмж, ажлын байр бий болгож, нийгмийн үйлчилгээг тэдэнд ойртуулах

#### **Зорилт 50.**

Хэрэглэгчид байгалийн гаралтай, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хийсэн, эвөрмөц хийц загвартай, нийтэд зориулсан их хэмжээний бус цөөн хувь үйлдвэрлэдэг, гар аргаар үйлдвэрлэсэн, чанартай бүтээгдэхүүнийг захиалгаар хийлгэж өндөр үнээр худалдан авах хандлагатай болж байгаа нь гар урчууд, жижиг бизнес эрхлэгчдэд таатай боломж гэж үзэж энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжих

#### **Зорилт 51.**

Шинжлэх ухааны ологтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж Баянхонгорын онцлогтой, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Шинжлэх ухааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтарсан компани байгуулж бодлгоор дэмжиж ажиллах

### **Зорилт 52.**

“Баянхонгорт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг сум болгонд салбартайгаар байгуулж, Улаанбаатар, томоохон хотуудын дэлгүүрийн сүлжээнд холбосноор Баянхонгорт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварийг сайжруулах

### **Зорилт 53.**

Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг эрхэлж байгаа бизнесийн төрөл чиглэлээр нь кластерийн зохион байгуулалтад оруулж хоршиж, хамтарч, нэгдсэн удирдлага менежментээр ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлснээр бизнесүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ба эхний ээлжинд бизнесийн дор дурдсан салбаруудад хэрэгжүүлэх

- ✓ *МАН-н түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх кластер*
- ✓ *Газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх кластер*
- ✓ *Барилгын материал үйлдвэрлэл, барилгаа угсралтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх кластер*
- ✓ *Чихэр өвс, лидер, зээрэгэнэ зэрэг эмийн ургамал, хужир шүү, давс зэрэг газар дээрх баялагуудыг тарималжуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх кластер*
- ✓ *Зочид буудал, зоогийн газар, тээвэр үйлчилгээний газрууд, амралт сузлал, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийг зохион байгуулалтад оруулж кластер үүсгэх*

### **3.3.3. Байгаль орчин, аялал жуулчлал**

#### **Зорилт 54.**

Гэл, горхи, булаг, шандны эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад гүнээс чийг татаж амьдрах чадвартай заг, тоорой, сухай, хайлаас зэрэг мод болон харгана, торлог, тэсэг, шавга, шар мод зэрэг бутлаг ургамлуудыг тарьж ногоон хэрмийг бий болгох, Түй, Байдраг, Шаргалжуут, Цагаан туруут зэрэг томоохон голуудын ай савын дагуу мод тарьж ойн сангийн хэмжээг нэмэгдүүлэх

#### **Зорилт 55.**

Түүх соёлын дурсгалт газар, ус, ой, эко систем, ховор ан амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч тухайн бүс нутагт ажиллаж, амьдарч буй иргэд, бүлэг, нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх

#### **Зорилт 56.**

Иргэддээ мод, бут, зүлэг, цэцэг тариалах, байгаль орчноо нөхөн сэргээх, эрүүл орчин бүрдүүлэх сургалт, семинар, сурталчилгааг оновчтой хэлбэрээр зохион байгуулж экологийн боловсрол олгох, айл өрх, албан байгууллагын хашаа, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон, сумын төв, Баянхонгор хот зэрэг суурин газруудыг ногоон хот болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа байгууллага, өрх, иргэдийг урамшуулах тогтолцоог бий болгохоос гадна иргэд,

нөхөрлөл, бүлгүүдийн тарьсан тарьц, суулгацыг худалдан авч дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх

**Зорилт 57.**

Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежментийн цогц бодлого хэрэгжүүлэх, ДЦС барих, гэр хорооллыг орон сууцжуулах замаар утаагүй орчинг бүрдүүлэх, орон нутгийн түлшний хэрэгцээг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн байгаль орчинд ээлтэй эко түлшээр бүрэн хангах;

**Зорилт 58.**

Хэрсэнгийн сувгийг татаж тэжээлийн ургамал тариалж тэжээлийн үйлдвэр байгуулж байсан туршлагадаа тулгуурлан томоохон голуудын гслдиролд тохируулга, усны хуваарилалт хийх аргаар бэлчээр усжуулж, тэжээлийн ургамал тариалан усалгаатай талбайг нэмэгдүүлэх, бололцостой газруудад хөв, цөөрмийг байгуулах

**Зорилт 59.**

Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз авсан аж ахуйн нэгжүүдтэй харилцан ашигтай хамтран ажиллах зарчмыг удирдлага болгож, санаачилгатай ажиллан тэднийг аймгийн эдийн засгийн хөгжилд татан оролцуулах

**Зорилт 60**

Бичил уурхайчид болон ХАМО иргэдийн мэдээллийн цахим сан үүсгэх, экологийг боловсрол олгох сургалтыг үе шаттайгаар явуулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгож мэргэжил эзэмшүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх санал, санаачлагыг дэмжихчиглэлээр холбогдох байгууллагууд хамтран ажиллах

**Зорилт 61.**

Ховор, нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх аймгийн бодлогыг тодорхойлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах;

**Зорилт 62.**

Архангай аймагт ирсэн аялагчдыг Хөл сая, Эгийн даваагаар дамжуулж аймгийнхаа хангайн чиглэлийн маршруттай холбох, Өвөрхангай аймагт ирсэн жуулчдыг Найман нуураас Элбэхийн даваагаар дамжуулж Шаргалжуутын маршруттай холбох, Өмнөговь аймагт ирсэн аялагчдыг Баянлигийн говийн маршруттай холбох стратегийг хэрэгжүүлснээр жуулчдын тоог нэмэгдүүлэх, Шаргалжуутад аялал жуулчлалын цогцолбор байгуулах

**Зорилт 63.**

Дотоодын аялалыг хөгжүүлэх зорилгоор Өргөөтийн рашаан, Өхөгийн амралт, Жаргалант сумын Биндэръяа Хөх нуур, Гурванбулагийн Хөх нуур, Бөөн цагаан нуур, Орог нуур, Эрхэт, Тамчийн хавцал, Өвгөнжар-алант болон байгалийн үзэсгэлэнт газруудыг тохижуулж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал(НИТАЖ)-ыг хөгжүүлснээр нүүдлийн ахуй соёлоо хадгалан үлдэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай эвент арга хэмжээнүүдийг бий болгох, жуулчдын урсгалыг татах нөхцлийг бүрдүүлэх.



**“ДӨРӨВ: ДЭД БҮТЭЦ, ХӨГЖЛИЙН ТЭГШ  
БОЛОМЖ”**

### 3.4. ДЭД БҮТЭЦ, ХӨГЖЛИЙН ТЭГШ БОЛОМЖ

#### **Зорилт 64.**

Баянхонгор аймаг нь нийслэл хотыг баруун аймгуудтай холбосон замын дунд байрладаг байршлын давуу талаа ашиглан **“Баруун зам”** төслийг хэрэгжүүлж баруун аймгуудыг нийслэлтэй холбосон тээвэр логистикийн оновчтой бсдлогыг хэрэгжүүлэх

#### **Зорилт 65.**

Авто замын салбарыг хөгжүүлэхэд улсын ба орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж Баянхонгор хотын авто замыг шинэчлэх хүрээнд 30км, Баянхонгор хот-Шаргалжуутын чиглэлийн 60 км замуудыг тус тус барьж, Баянхонгор-Баянлиг чиглэлийн 212 км хатуу хучилттай замын барилгын ажлыг эхлүүлж, Баянлиг-Гурвантэс чиглэлийн 293 км, Баянхонгор-Баянбулаг чиглэлийн 237 км хатуу хучилттай авто замын зураг төсвийг хийж барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлэх

#### **Зорилт 66.**

Аймгийн хэмжээнд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжит хувилбаруудыг судлан, нар, салхи, нар салхины хосолмол эрчим хүчийг ашиглах, Баянхонгор хотод дулааны цахилгаан станц барьж, хэрэглээний халуун усны төвлөрсөн системтэй болох ба хуучирсан дулааны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлыг ээлж дараатай хэрэгжүүлэх

#### **Зорилт 67.**

Сумдыг инженерийн шугам сүлжээнд холбож, бага оврын халаалтын зуух бүхий хэрэглэгчдийг дулааны эрчим хүчний нэгдсэн системтэй холбох;

#### **Зорилт 68.**

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үүрэн телефоны операторуудтай харилцан ашигтай нөхцлөөр хамтран ажиллах нөхцлөөр аймгийн нийт нутаг дэвсгэрийн аль ч байрлалд сүлжээтэй болж иргэд гэрээсээ, малынхаа бэлчээрээс дэлхийтэй холбогдох бололцоог бүрдүүлэх

#### **Зорилт 69.**

Шинэ зууны хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологжсон, ажиллаж амьдрахад таатай, а-оулгүй ухаалаг аймгийг бий болгоход чиглэгдсэн **“Ухаалаг -Баянхонгор”** хөтөлбөр хэрэгжүүлэх

#### **Зорилт70.**

Өндөр хурдны шилэн кабелийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар бизнесийн шинэ боломжуудыг орон нутагт бий болгож зах зээлийн мэдээллийн орон зайн зааг ялгааг арилган мэдээллийн хурдыг сайжруулах, **“Цахим Монгол”** хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет хөтөлбөрийг зохион байгуулж, бүх сумдын төвд интернет мэдээллийн төв ажиллуулах

#### **Зорилт 71.**

Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэр төрлийг нь олшруулах, барилгын компаниудын зах зээлд

өрсөлдөх чадварыг дээшлүүлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах чадвар бүхий корпораци, концерциум байгуулан ажиллуулах санал санаачилгыг дэмжих

**Зорилт 72.**

Баянхонгорсумын багуудад шинэчлэн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбож тохилог орчинд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх

“ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ”



МОНГОЛ УЛС

2050

2030

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

ТОРИЙН ОРДОН

2013 оны 11 дүгээр сарын 16

“ТАВ: УХААЛАГ ТӨР-ХӨГЖЛИЙН  
ЗАЛУУР”

### **3.5. УХААЛАГ ТӨР-ХӨГЖЛИЙН ЗАЛУУР**

#### **Зорилт 73.**

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг хариуцлагатай, бодлогоо судалгаагаар боловсруулж бсдитойгоор хэрэгжүүлдэг, уян хатан, чадавхтай, өндөр бүтээмжтэй, хүнд сурталгүй, иргэдэд төсийн үйлчилгээг ойртуулсан, иргэдээ нийгмийн сайн сайханд хөтөлсөн хөдөлгөгч хүч байхаар хөгжүүлэх

#### **Зорилт 74.**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг иргэдийн санал, газар зүйн байршил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан сумдыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг чиг баримжаа болгож, бүлэг суурингийн тогтолцоог бүрдүүлэн зах зээлийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх

#### **Зорилт 75.**

Аймаг, сумдын ИТХ нь, аймаг, сумдын ИТХ-ыг сонгох сонгуульд өрсөлдөж байгаа улс төрийн намууд сонгуульд оролцох хөтөлбөртөө "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ыг иш үндэс болгож хөгжлийн бодлогын үзэл санаа, зорилтуудыг тусгаж байх, сумдын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд Хөгжлийн бодлогын үе шатны ажлуудыг тусгаж хэрэгжүүлж байх эрх зүйн орчинг бүрдүүлэх

#### **Зорилт 76.**

Аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн шийдвэрээр аймгийн ИТХ-ын дэргэд "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх бүтэц, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дэргэд аймаг, сумдын Засаг дарга нараар ахлуулсан "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ын хэрэгжилтийг зохион байгуулах бүтцийг тус тус байгуулж ажиллах

#### **Зорилт 77.**

"Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-д тодорхойлсон төсөл, хөтөлбөрүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Баянхонгорийн хөгжлийн корпораци" ХК-ийг байгуулж, холбогдох дүрэм, журмуудыг баталж үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх эрх зүйн орчинг нь бүрдүүлэх

#### **Зорилт 78.**

Төрийн байгууллагуудад ажлаа мэддэг, практик туршлагатай, менежментийн өндөр мэдлэг, ур чадвартай менежерүүдийг ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тулгуурлан дэвшүүлж ажиллуулах, тасралтгүй сурган хөгжүүлэх олон улсын жишигт хүрсэн механизмийг бий болгох

#### **Зорилт 79.**

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааг мэргэжлийн байгууллага, судлаач нартай хамтран боловсруулж, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Баянхонгор аймгийн хөгжлийн хөтөч болсон өндөр ур чадвартай мэргэшсэн, нарийн мэргэжлийн, хариуцлагатай, нутаг орноо хөгжүүлэх сэтгэлтэй, сэтгэлгээний хурдтай, чадварлаг хүний нөөцийг салбар бүрээр бэлтгэх, хөгжүүлэх системтэй бодлого хэрэгжүүлэх



**Зорилт 80.**

Гадаад, дотоодын нэр хүнд бүхий сургуулиудад жил бүр тодорхой тооны залуучуудыг сонгон шалгаруулж тэтгэлэг олгох замаар сургаж, дадлагажуулахын зэрэгцээ гадаадын улс орнуудад сурч, ажиллаж амьдарч байгаа шилдэг сэхээтнүүд, тодорхой мэргэжил, ажил үйлчилгээгээр өндөр түвшинд мэргэшсэн ажилтнууд, гадаад, дотоодын олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүд, эрдэмтэд, судлаачид, нутгийн боловсон хүчний зөвлөгөө дэмжлэгийг орон нутгийн хөгжилд татан оролцуулах нөхцлийг бүрдүүлэх

**Зорилт 81.**

Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг бэхжүүлнэ гэсэн Засгийн газрын зорилтыг үндэс суурь болгон Баянхонгор аймаг нь улс орнуудтай гадаад харилцааны бодлогын уламжлал болон залгамж чанарыг хадгалан түншлэлийн харилцааг бүх талаар хөгжүүлэн бэхжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засгийн өсөлтийг тогтвортой болгож, орон нутгаа хөгжүүлэх.

**ДӨРӨВ: “БАЯНХОНГОР АЙМГИЙН 2016-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТ”-ЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД**

(I үе шат 2016-2020 он, II үе шат 2021-2025 он)

## ДӨРӨВ: “БАЯНХОНГОР АЙМГИЙН 2016-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТ”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТУУД

(I үе шат 2016-2020 он, II үе шат 2021-2025 он)

### Үе шат I. (2016-2020 он)

- Хүний хөгжлийн суурь үе болох цэцэрлэгийн насны хүүхдээс эхлэн хөдөлмөрийн хүмүүжил олгох, ухаан сэтгэхүйг нь хөгжүүлэх зорилгоор монголын "Оюун ухааны академ"-ийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, монголын онцлогтой тоглоомын үйлдвэр байгуулж нийт цэцэрлэгийн 30 хүртэл хувийг хангах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдийн 90 хувийг хамруулах нөхцлийг бүрдүүлэх
- ЕБС-д суралцагсадад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, МСҮТ, Коллежид суралцагсадын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, нийт сургуулийн 25 хүртэл хувьд "Үйлдвэрлэл дадлагын бааз, бизнес инкубаторын төв" -ийг байгуулах
- Насанд хүрэгсдэд тасралтгүй боловсрол олгох, иргэдийг баялаг бүтээх дадал хээшилд сургаж, хөдөлмөрт хандах хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн Амьдрах Ухааны Их Сургууль (албан бус сургалтын хөтөлбөр)-ийг боловсруулж бүх сум, байгууллагуудад хичээлүүлж эхлэх
- Хүн амын өмчлөл, нас баралтад нөлөөлж буй амьдралын буруу хэвшил, дадал, орчны бохирдол, хүнсний аюулгүй байдал, осол гэмтэлд өртөх зэрэг эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх, байгууллага бүр дээр эрүүл мэндийг дэмжих орчинг бүрдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар өвчлөлтийг бууруулж хүн амын дундаж наслалтыг 71,9-д хүргэх
- Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 30, тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах
- Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх "24428 үйлдвэр" төслийг боловсруулж хэрэгжүүлж эхлэх. Энэ төсөл нийт өрхийн 25 хүртэл хувьд хэрэгжиж эхэлсэн байх
- Ядуу, эмзэг бүлгийг орлогын байнгын эх үүсвэртэй болгох эдийн засгийн орчинг бүрдүүлэн нийгмийн халамжийн тогтолцоог зорилтод бүлэгрүү чиглүүлэх замаар ядуурлын түвшинг 18 хүртэл бууруулж, ажилгүйдлийн түвшинг 4,0 хувьд хүргэх
- Иргэн бүрийн аймгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах бололцоо нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн гаргасан нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах бололцоотой **"Шилдэг бүтээл, дэвшилтэд технологи, оновчтой санал"** -ыг үнэлж төрөөс худалдан авч урамшуулах тогтолцоог бий болгох
- Баянлиг сумын ингэний сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, Эрдэнэцогт сумын сарлагын сүү боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж Галуут, Бууцагаан, Жаргалант, Баянхонгор суманд сүүний үйлдвэр байгуулах

- Сарлагын хөөвөр боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хонины ноосоор дулаалгын материал үйлдвэрлэх үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах
- Ноолуур боловсруулах, хонь, тэмээний ноососр утас ээрэх үйлдвэрүүдийн ТЭЗҮ-г хийж олон улсын байгууллагуудад хандах, хөрөнгө оруулагч олж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Мах сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын хил хязгаарыг тодорхойлж, тус бүс нутагт "Эрүүл мал-эрүүл хүнс" бодлогыг хэрэгжүүлэн, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг үе шаттай хэрэгжүүлж эхлэх
- Бүсийн төвүүдэд жижиг оворын махны үйлдвэр байгуулах ТЭЗҮ-г хийж, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах, мал бордох цэгийг 5-аас доошгүй суманд байгуулах
- Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй байгуулах санал, санаачлагыг дэмжиж үйл ажиллагааг эхлүүлэх
- Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй, 50-150 км-ийн алслагдсан тойрогт хагас суурин мал аж ахуй, 150 км-ээс цааш алслагдсан тойрогт уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах
- Газар тариалангийн салбарт дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх асуудлыг тэргүүлэх бодлого гэж үзэж 2020 он гэхэд аймгийнхаа төмсний хэрэглээний 86 хувь, хүнсний ногсоны хэрэглээний 65.4 хувийг хангаж, малын тэжээлийн ургамал тариалалтыг 12.4 хувиар нэмэгдүүлэх
- Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт болон Шаргалжуутад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн аж ахуй (хамгаалагдсан хөрсний тариалалт)-г хөгжүүлж орон нутгийн нарийн ногооны хэрэглээний 30 хувийг хангах
- Импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүнээс аймаг орон нутаг үйлдвэрлэх бололцоотой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгааг гаргаж, импортыг орлох хэмжээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэхээр төсөл, хөтөлбөр боловсруулсан, энэ чиглэлийн бизнесийг хийж эхэлж байгаа иргэд, өрх, жижиг бизнес эрхлэгчдийг сонгон бодлогоор дэмжиж, импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүний нэр төрлийг 20 хувиар бууруулах
- Баянхонгор хотод баригдаж байгаа "Ажилсаг төв"-ийн барилгын ажлыг дуусгаж, тус төвийг түшиглэн "Баянхонгор үйлдвэр технологийн парк"-ийг байгуулах
- Хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх эхлэлийг тавьж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 25 хувийг, сүүний 20 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, хүн амын хэрэгцээг эрүүл, баталгаат хүнсээр хангах
- Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж Баянхонгорын онцлогтой, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоср Шинжлэх ухааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтарсан компани байгуулах
- Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг одоогийн түвшингээс 1 дахин нэмэгдүүлэх

- Баталгаат унднь усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 60 -д хүргэж, төв суурингийн хүн амын 10 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжинд хамруулах
- Хст суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувийг 20 -д хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх
- Баянхонгор хотын утааг бууруулах, иргэдийн тав тухтай байдлыг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ДЦС-ийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, утаагүй түлшний үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах
- Өвөрхангай аймгийн Орхоны хөндийн түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газраар аялах аялагчдын урсгалыг Шаргалжуутын рашаанлуу татах хамгийн дөт зам болох Замтын давааны замыг засаж, сайжруулах ажлыг гүйцэтгэснээр Баянхонгорт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх
- Өмнөговь аймагт Монгслын говь нутгийг үзэх гэж ирж байгаа жуулчдын урсгалыг Баянлигийн хүн үүслийн өлгий нутаг, Бичигтийн хөндийн хадны зураг, аварга биет үлэг гүрвэлийн амьдарч байсан нутаг болох Бүгийн цавын хоолойн аялалын маршруттай холбох ажлыг зохион байгуулах
- БНХАУ-ын Альшаа аймгийн Эзнээ хошуунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Алтан тоорой"-н баярт ирдэг жуулчдын урсгалыг Баянхонгорын говийн маршруттай холбох нөхцөл болсцоог бүрдүүлэх
- Баянхонгор хотын авто замыг шинэчлэх хүрээнд 10км, Баянхонгор хот-Шаргалжуутын чиглэлийн 60 км замуудыг тус тус барьж, Баянхонгор-Баянлиг чиглэлийн 212 кмхатуу хучилттай замын барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлэх
- Баянхонгор хотод ДЦС -ын барилга угсралтын ажлыг эхлүүлэх
- Нэг, салхины эрчим хүчээр ажилладаг, малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн бага оворын тоног хэрэгслэлээр нийт малчин өрхийн 30 хувийг хангах
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оворын үйлдвэрүүд байгуулж, Баянхонгор хотын гэр хорлоолтын айл өрхийн 30 хувийг хангах
- Шинэ зууны хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологжсон, ажиллаж амьдрахад таатай, аюулгүй ухаалаг аймгийг бий болгоход чиглэгдсэн "Ухаалаг -Баянхонгор" хөтөлбөр хэрэгжүүлж эхлэх
- Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхүүдийн 50 хувийг инженерийн шугам сүлжээнд холбох
- Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэх хүчин зүйлүүдийг нэг болох төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж үр дүнд чиглэсэн, идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх
- "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт"-ын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий ИТХ, Засаг даргын Тамгын газрын дэргэдэх бүтцүүдийг байгуулж үйл ажиллагаагаа

хэрэгжүүлэх эрх зүйн орчин, чиг үүрэг, хүрэх үр дүнг тодорхойлж ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх

- “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт”-ын эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйлдвэржилтийн хөтөлбөрүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх “Баянхонгорийн хөгжлийн корпораци” ХК-ийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэх

#### **Үе шат II. (2021-2025он)**

- Монголын “Оюун ухааны академ”-ийн сургалтын хөтөлбөрбүх сургуулиудад хэрэгжиж, Баянхонгорт үйлдвэрлэсэн монголын онцлогтой тоглоомоор нийт цэцэрлэгийг 100 хувь хангаж сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулах
- Аймгийн нийт ЕБС-ийн 50 хувьд “Үйлдвэрлэл дадлагын бааз, бизнес инкубаторын төз” -ийг байгуулсан байх
- Амьдрах Ухааны Их Сургууль (албан бус сургалтын хөтөлбөр)-ийн сургалтын 2 дахь шатны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлүүлэх
- Эрүүл аж төрөх хэв маягийг өргөжүүлж “Эрүүл байгууллага”, “Эрүүл баг”, “Эрүүл сум” болзолт уралдааныг жил бүр шалгаруулан урамшуулах тогтолцоог бий болгож, хүн амын өвчлөлт, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулснаар хүн амын дундаж наслалтыг 75.0-д хүргэх
- Эхийн эндэгдлийн түвшинг 100000 амьд төрөлтөд 25, тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах
- “24428 үйлдвэр” төсөлд нийт өрхийн 50 хувийг хамруулсан байх
- Ядуу, эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж, ажиллах үр чадварыг дээшлүүлэх тусгалцоог сайжруулах, нийгмийн халамжийн үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлэх, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд, ажилгүйдлийн түвшинг 3,0 хувьд хүргэх бууруулах
- Эдийн засгийн идэвхтэй хүн амын 30 хувь нь орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах бололцоотой “Шилдэг бүтээл, дэвшилтэд технологи, онэвчтой санал”-ыг гаргаж, урамшуулаг хүртсэн байх
- Орон нутгийн сүүний үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүнээр аймгийн хэрэглээг бүрэн хангаж, үндэсний болон гадаадын зах зээлд гархад нь дэмжлэг үзүүлсэн байх
- Сарлагын хөөврөөр хийсэн бүтээгдэхүүн болон хонины ноосоор хийсэн дулаалгын материалыг зах зээлд нийлүүлж, ноолуур боловсруулах, хонь, тэмээний ноосоор утас зэрэг үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх
- Мах, сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрч, “Эрүүл бүс” нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлах
- Аймгийн 3-аас доошгүй бүсийн сумын төвд жижиг оворын махны үйлдвэр, мал бордох цэгийг 5-аас доошгүй суманд, гахай, тахиааны 5-аас доошгүй аж ахуйг байгуулсан байх

- Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт мах, сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй, 50-150 км-ийн алслагдсан тойрогт хагас суурин мал аж ахуй, 150 км-ээс цааш алслагдсан тойрогт уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхлэх
- Аймгийнхаа төмсний болон хүнсний нэгооны хэрэглээг 100 хувь хангаж, малын тэжээлийн ургамал тариалалтыг 20 хувиар нэмэгдүүлэх
- Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт болон Шаргалжуутад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн аж ахуй (хамгаалагдсан хөрсний тариалалт)-г хөгжүүлж орон нутгийн нарийн ногооны хэрэглээний 50 хувийг хангах
- Баялаг бүтээгч иргэд, өрх, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон гадаад, дотоодын хөрөнгө осуулалттай аж ахуй нэгжүүдийг дэмжсэнээр импортсор авч байгаа бараа, бүтээгдэхүүний нэр төрлийг 40 хувиар бууруулах
- Импортыг орлох болон экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж байгаа бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд "Баянхонгор үйлдвэр технологийн парк"-аар дамжуулан шинэ, дэвшилтэт болон өндөр технологийн эвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх
- Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаат хүнсээр хангах, үндэсний болон олон улсын зах зээлд "Баянхонгор брэнд" хүнсний бүтээгдэхүүн гаргах
- Шинжлэх ухаань байгууллага, их дээд сургуулиудын судалгаа шинжилгээний ажлын үр дүн, ололтыг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн, мэдлэг шингэсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийн тоо өссөн байх
- Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийн 40-өөс доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлэх
- Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 65-д хүргэж, төв суурингийн хүн амын 20 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжинд хамруулах
- Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 -д хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх
- ДЦС-ийг ашиглалтад оруулж, иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, гэр хорооллын иргэдийг утаагүй түлшээр хангаснаар аймгийн төвд утаагүй орчинг бүрдүүлэх
- Өвөрхангай аймгийн Орхоны хөндийн түүх сөөл, байгалийн үзэсгэлэнт газраар аялах аялагчдын урсгалыг Шаргалжуутруу татах нөхцлийг бүрдүүлснээр Өвөрхангай аймгаар дамжиж ирэх жуулчдын тоог 3000 хүргэх
- Өмнөговь - Баянхонгорын гозийн бүс нутгаар аялах аялагчдын урсгалыг бий болгосноор Өмнөговь аймгаар дамжиж ирэх жуулчдын тоог 2000 хүргэх
- БНХАУ-ын Альшаа аймгийн Эзнээ хошуунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Алтан тоорой"-н баярт ирдэг жуулчдын урсгалыг Баянхонгорын говийн маршруттай холбөж ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх

- Баянхонгор хотын авто замыг шинэчлэх хүрээнд 10км, Баянхонгор хот Шаргалжуут чиглэлийн 60 км замуудыг тус тус барьж, Баянхонгор-Баянлиг чиглэлийн 212 кмхатуу хучилттай замын барилгын ажлыг эхлүүлэх
- Баянхонгор хотод ДЦС баригдсанаар аймгийн төвийн утааг 50 хувь бууруулах
- Нэр, салхины эрчим хүчээр ажилладаг, малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн бага оворын тоног хэрэгслэлээр нийт малчин өрхийн 50 хувийг хангах
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оворын үйлдвэрүүд байгуулж, Баянхонгор хотын гэр хорлооллын айл өрхийн 60 хувийг хангах
- "Ухаалаг -Баянхонгор" хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн үйлчилгээний хурд 50 хувиар хурдасч, Баянхонгорт бизнес эрхлэх зардал 20-30 хувиар багасч, иргэд төрийн 200-аас дээш үйлчилгээг нэг цонхоор авдаг болно
- Аймгийн төвийн гэр хорооллын айл өрхүүдийн 50 хувийг инженерийн шугам сүлжээнд холбох
- Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, уул уурхайн салбарын 4 талын түншлэлийн идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд хөгжлийн хөтөлбөрийн үе шатны зорилтууд хэрэгжсэн байх
- Аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газрын дэргэдэх бүтцүүдийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтын ажлын үр дүнд аймгийн хөгжлийн хэтийн зорилт хэрэгжсэн байх
- "Баянхонгорийн хөгжлийн корпораци" ХК-ийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр аймаг, орон нутагт үйлдвэрлэсэн голлох нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр орон нутгийн хэрэгцээг хангаж, Баянхонгорт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргаж эхэлсэн байх



ТАВ: "БАЯНХОНГОР АЙМГИЙГ 2016-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ  
ХЭТИЙН ЗОРИЛТ"-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ,  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

**ТАВ: “БАЯНХОНГОР АЙМГИЙГ 2016-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН  
ЗОРИЛТ”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ,  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэггээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгаж хэрэгжих таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийн бүлэг, дэд бүлэг бүрт багтсан тэргүүлэх зорилтуудын хүрээнд тусгасан үзүүлэлтүүдийг үндэслэн хийнэ.

Баянхонгор аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтыг 2016-2025 онд бүх нийтээрээ дагаж мөрдөх бөгөөд энэ нь бүх шатны байгууллага иргэдэд, Баянхонгор аймгийн хөгжил ямар түвшинд очих, ямар замналаар хөгжих, ирээдүйд ямар сорилтууд тулгарах, түүнийг хэрхэн даван туулах зэргийг зааж өгсөн хөгжлийн бодлогын суурь баримт бичиг болох юм.

Хөгжлийн хэтийн зорилт нь бүх шатны албан байгууллагын дунд, богино хугацааны бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээнд нарийн тусгалаа олж, аймгийн хөгжлийн хэтийн зорилтын зорилгыг хангахад чиглэгдсэнээр амжилттай хэрэгжих үндэс бүрдэнэ. Иймд орон нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон иргэд Баянхонгор аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг холбогдох эрх зүйн актуудын дагуу хэрэгжүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

Баянхонгор аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилт нь үр дүнд чиглэсэн байна. Үр дүн нь хэтийн зорилтыг хэрэгжүүлснээр бий болох гарц(бүтээгдэхүүн), үр дагавар болон үр нөлөөгөөр хэмжигдэнэ.

*Гарц, үр дагавар, үр нөлөөний уялдаа*

Үр дүнгийн уялдаа					
Тухайн бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх вэ?		Ямар бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болох вэ?	Энэ хөрөнгө оруулалтын үр дүнд бид ямар үр дагаврыг хүлээж байна вэ?		Тухайн бодлогыг яагаад хэрэгжүүлэх шаардлагатай вэ?
Орц	Гарц	Бүтээгдэхүүн	Богино хугацааны үр дагавар	Дунд хугацааны үр дагавар	Урт хугацааны үр нөлөө


**Тайлбар:**

- **ОРЦ:** төсөл, хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, хүний болон бусад материаллаг нөөц
- **ҮЙЛ АЖИЛЛАГАА:** орцыг бүтээгдэхүүн, гарц болгон хувиргахад авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- **ГАРЦ:** тодорхой зорилтод хүрэхийн тулд явуулсан үйл ажиллагаан үр дүнд бий болсон, холбогдох талуудад нийлүүлж буй эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
- **ҮР ДАГАВАР:** дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн д зан үйл, ойлголт, мэдлэгийн түвшинд гарсан өөрчлөлт

➤ **ҮР НӨЛӨӨ:** нийгэмд урт хугацаанд бий болсон өргөн хүрээний өөрчлөлт

Хөгжлийн хэтийн зорилтыг дунд, богино хугацааны салбарын болон орон нутгийн бодлогод тусган төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүгийн тзоцоолол хийх, санхүүжүүлэх, хөгжлийн хэтийн зорилт болон дунд, богино хугацааны бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаа нь үр дүнд суурилсан байна.

*Үр дүнд суурилсан удирдлага*



Салбар болон орон нутгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлого төлөвлөхөөс, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бүх шатанд хөгжлийн хэтийн зорилтын зорилго, зорилтуудыг уялдуулсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хэтийн зорилтын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, хэрэгжилтийг сайжруулах, хэрэгжилтийг салбарын болон орон нутгийн түвшинд уялдуулахдаа салбарын болон орон нутгийн шалгуур үзүүлэлтүүдийг хөгжлийн зорилтын үе шат бүрт тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт - шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Шалгуур үзүүлэлтүүдийн уялдаа, хэрэгжилтийн талаарх мэдээг нутгийн захиргааны байгууллагууд доорх хүснэгтийн дагуу гаргана.

*Шалгуур үзүүлэлтийн хүснэгт*

Зорилт/үр дүн	Хэтийн зорилтын бүлэг/заалт	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилтот түвшин (хугацааны)	Хариуцах байгууллага
			Суурь он	Суурь түвшин		

				эцэст)	

Шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, ач холбогдолтой болон цаг хугацаатай байна. Шалгуур үзүүлэлтүүд нь уян хатан байх бөгөөд хөгжлийн зорилтын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн амжилт ололт, алдаа оноондоо дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шалгуур үзүүлэлтүүд тэдгээрийн зорилтод түвшинд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Баянхонгор аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтэд хөгжлийн бодлого батлагдсанаас хойш 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, таван жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийнэ.

Хөгжлийн хэтийн зорилтын хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой төсөв, санхүүгийн зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч бүр жил бүрийн төсөвтөө суулган батлуулна.

Баянхонгор аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийн тайланг бүх төрийн захиргааны байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд гаргаж, нэгтгэсэн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газар аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд жил тутам танилцуулна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн зөвлөмжийн биелэлтийг бүх шатны байгууллага хангаж, аймгийн Засаг даргын Тамгын газар биелэлтэд нь хяналт тавина.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_